



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

ЯДУУРЛЫН ТООЦООНЫ АРГА ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ, ҮР ДҮН 2022



Улаанбаатар хот
2025 он





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

ЯДУУРЛЫН ТООЦООНЫ АРГА ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ, ҮР ДҮН - 2022

© 2025 Дэлхийн банк
Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.

Энэ тайлан нь Дэлхийн банк, Үндэсний статистикийн хорооны хамтын бүтээл юм. Энэхүү бүтээлд илэрхийлсэн тайлбар, дүгнэлтүүд нь Дэлхийн банк, түүний Гүйцэтгэх захирлуудын зөвлөл, Үндэсний статистикийн хороо болон Монгол Улсын Засгийн газрын үзэл баримтлалын илэрхийлэл болохгүй.

Энэхүү бүтээлийн агуулга, үзэл санаа, дүгнэлт нь зөвхөн зохиогчдынх бөгөөд ДБ нь тоо мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах үүрэг хүлээгээгүй болно. Энэхүү бүтээлд дурдсан газарзүйн бүс нутаг, хил хязгаар, ашигласан өнгө, нэр томъёо болон бусад мэдээлэл нь аливаа нутаг дэвсгэрийн эрх зүйн байдлын талаар Дэлхийн банк, Үндэсний статистикийн хорооны зүгээс баримталж буй үзэл санааг агуулаагүй болно.

Бусад зохиогчдын бүтээлийг иш татсан нь Дэлхийн банк тухайн бүтээлүүдийн агуулга эсвэл зохиогчийн үзэл бодлыг дэмжиж байгаа гэсэн үг биш юм. Энд дурьдсан зүйл нь Дэлхийн Банкны давуу эрх, халдашгүй дархан эрхийг хязгаарлах, татгалзах явдал гэж үзэх ёсгүй бөгөөд эдгээр эрхүүдийг тусгайлан хадгална.

Эрх болон зөвшөөрөл

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан болно. Эх сурвалжийг тодорхой дурдсан тохиолдолд ашгийн бус зорилгоор энэхүү бүтээлээс иш татаж эсвэл хэсэгчлэн хуулбарлан ашиглаж болно.

Эрх, лицензтэй холбоотой асуудлаар World Bank Publications, The World Bank Group, 1818 H Street NW, Washington, DC 20433, USA; fax: 202-522-2625; e-mail: pubrights@worldbank.org хаягаар хандана уу.

Хавтасны дизайн: Лувсандоржийн Хануй

Дэлхийн банк
1818 H Street NW
Вашингтон, DC 20433 АНУ
Факс: 202-522-2625
Имэйл: pubrights@worldbank.org

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
Засгийн газрын III байр Бага тойруу-44,
Улаанбаатар -11, Монгол Улс
Утас: (976-11)-321433 | 1900-1212
www.nso.mn

ӨМНӨХ ҮГ (ҮСХ)



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГА

Б.БАТДАВАА

Монгол Улс дэлхий дахинд ядуурлыг устгах, эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалах, энх тайван, хөгжил цэцэглэлтэд хүрэх боломжийг бүрдүүлэхэд дуудсан “Хөгжлөөс хэн ч үлдэх, хоцрох ёсгүй” уриалгад нэгдэн, Тогтвортой хөгжлийн зорилтууд, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Тогтвортой хөгжлийн зорилт нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн нэгдмэл, тэнцвэрт, тогтвортой хөгжилд хүрэх гурван тулгууртай бөгөөд ирээдүйд биелүүлэхээр зорьж буй багц зорилтуудын нэгдэл юм.

Дээрх зорилтуудад хүрэх суурь нь ядуурал, өлсгөлөнгийн бүх хэлбэрийг эцэс болгох, хүний эрхийг дээдлэх, эрх тэгш байдлыг бүрдүүлэх юм. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, цаашид шаардлагатай бодлого, хөтөлбөрийг боловсруулахад ядуурлын талаарх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцсон тоо мэдээллийг бий болгоход Үндэсний статистикийн хороо анхаарч ажилласаар ирсэн.

Үндэсний статистикийн хорооноос хүн амын хэрэглээний мэдээлэлд үндэслэн ядуурлын үзүүлэлтийг тооцох боломжтой “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г зохион байгуулан явуулдаг бөгөөд 2002 оноос эхлэн Дэлхийн банктай ядуурлыг хэмжих арга зүйг боловсруулах, тооцоолол хийх чиглэлээр нягт хамтран ажиллаж ирсэн.

Монгол Улсын хувьд 2010 он хүртэл ядуурлын шугамыг жил бүр шинэчлэн тооцож ирсэн бол 2012 оноос 2010 оны ядуурлын шугамыг суурь болгож, хэрэглээний үнийн индексээр индексжүүлэх замаар урт хугацаанд ядуурлыг харьцуулах боломжтой болгосон.

Дэлхийн Банк болон олон улсын байгууллагуудын зөвлөмжийн хүрээнд ядуурлын суурь шугамыг арван жилийн давтамжтай шинэчилж, хүн амын амьжиргааны хэв шинжид гарч буй өөрчлөлтийг тусгадаг. Энэхүү зөвлөмжийн дагуу Дэлхийн Банкны техникийн туслалцаатайгаар ядуурлын суурь шугамыг үндсэн хэрэгцээний зардлын аргад суурилан 2022 оноор шинэчлэн тооцлоо. Мөн Дэлхийн Банкаас ядуурлыг хэмжих, хэрэглээний иж бүрдлийг байгуулах аргачлалыг 2022 онд шинэчилж, улс орнуудад зөвлөмж болгосон. Энэхүү аргачлалд үндэслэн Монгол Улсын ядуурлын шугамыг тооцох, хүн амын хэрэглээний бүрэлдэхүүн байгуулах зарчимд тодорхой өөрчлөлтүүдийг тусгаж, “Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж, үр дүнг нийтэд танилцуулсан.

Энэ удаагийн тайланд ядуурлын шугамын шинэчлэл болон арга зүйд орсон гол өөрчлөлтүүд, мөн 2022 оны байдлаарх хүн амын ядуурлын дүр төрхийг тусган орууллаа. Судалгааны үр дүн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, олон улсын байгууллага, эрдэмтэн, судлаачдад чухал мэдээллийн эх үүсвэр болно гэдэгт найдаж байна.

Судалгааны мэдээллийг олон улсын аргачлалын дагуу тооцоход техникийн дэмжлэг үзүүлсэн, тоо мэдээлэл, тайлан боловсруулахад хамтран ажилласан Дэлхийн Банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Таехюн Ли, эдийн засагч хатагтай Лидия Ким болон ядуурлын судалгааны мэргэжилтнүүд, Монгол Улс дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газрын хамт олонд талархал илэрхийлье.

ӨМНӨХ ҮГ (ДЭЛХИЙН БАНК)



ДЭЛХИЙН БАНКНЫ МОНГОЛ
УЛСЫГ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

ТАЕХЮН ЛИ

Монгол Улс сүүлийн арван жилийн хугацаанд эдийн засгаа хөгжүүлэн ядуурлыг бууруулах чиглэлээр ихээхэн ахиц дэвшил гаргасан хэдий ч улс орон хөгжихийн хэрээр бий болж буй эдийн засгийн өсөлтийг нийт хүн амд хүртээмжтэй болгох нь нэн тэргүүний зорилт хэвээр байна. Ядуурлын дүр төрх тайлан нь 2022 оны Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин, тэгш бус байдлыг илэрхийлэхээс гадна эмзэг бүлгийн хүмүүст тулгарч буй хүндрэл бэрхшээл, сорилтуудын талаар үнэтэй ойлголтуудыг бидэнд өгөх болно. Монгол Улс тогтвортой олон талт төрөлжсөн эдийн засгийг бий болгон нийгмийн болон бүс нутгийн ялгааг бууруулах замаар иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтыг “Алсын хараа 2050” бодлогын баримт бичигт тусгасан байдаг. Энэ тайлан нь бодлогын зорилтыг хэмжих гол үзүүлэлт болох ядуурлын дүр төрхийг харуулахаас гадна эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх цаашдын бодлого боловсруулах суурь мэдээлэл болох юм.

Энэхүү тайлан нь Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) болон Дэлхийн Банкны тууштай хамтын ажиллагааны үр дүн бөгөөд Өрхийн нийгэм, эдийн засгийн 2022 оны судалгаанд үндэслэн боловсруулсан шинжилгээ, дүгнэлт нь нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, үр ашигтай бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх болно. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын талаар бодитой дүр зургийг харуулах зорилгоор энэхүү судалгааг зохион байгуулан явуулж, өгөгдлийг цуглуулан боловсруулж, шинжилгээ хийх зэрэг бүх шатны үйл ажиллагаанд ҮСХ-ны манлайлал чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Тайлангийн гол дүгнэлтээс товч дурдахад, хөдөө орон нутгийн ядуурлын түвшин хот суурин газрынхаас харьцангуй өндөр байгаа нь ядууралд бүс нутгийн ялгаатай байдал их байгааг илтгэж байв. Хүмүүсийн боловсролын түвшин өндөр байх нь ажилтай, өндөр орлоготой болох боломжийг нэмэгдүүлж ядуурлаас ангижрах, таслан зогсоох үндсэн хөшүүрэг мөн болохыг онцлон тэмдэглэжээ. Нэмж дурдахад тогтвортой, тууштай хөдөлмөр эрхлэлт, үндсэн үйлчилгээ болон дэд бүтэц хүртээмжтэй байх нь өрхийн аж байдал сайжрах, сайн сайхан байдал нэмэгдэхэд ач холбогдолтой хэвээр байна. Эдгээр тэгш бус байдлыг арилгах нь Монгол Улсын “Алсын Хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын ядуурлыг бууруулах, илүү тэгш нийгмийг бий болгох зорилтод хүрэх гол түлхүүр юм.

Дэлхийн Банк Монгол Улсыг ядуурлыг бууруулах, хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн хэвээр байна. Энэхүү тайлан нь чинээлэг, хүртээмжтэй, хүчирхэг Монгол Улсыг бий болгоход бодлого боловсруулагчид, хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн байгууллагуудад үнэ цэнэтэй мэдээллийн эх үүсвэр болно гэж найдаж байна.

Өндөр хичээл зүтгэл гарган хамтран ажилласан ҮСХ-ны хамт олон болон хувь нэмрээ оруулсан бүх оролцогч талуудад талархал илэрхийлье. Цаашид бид Монгол Улсын иргэдийн аж байдлыг дээшлүүлэхэд нотолгоонд суурилсан бодлого боловсруулах хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийг зорин ажиллах болно.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ (ҮСХ)	3
ӨМНӨХ ҮГ (ДЭЛХИЙН БАНК)	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	8
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	9
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	10
ХУРААНГУЙ	14
БҮЛЭГ 1:	
ядуурлыг хэмжих шинэчилсэн аргачлал	18
БҮЛЭГ 2:	
ядуурал 2022 онд	36
БҮЛЭГ 3:	
ядуурлын дүр төрх 2022 онд	43
ХАВСРАЛТ	
Хавсралт А. Онцгой утгын засварлалт, хүнсний ядуурлын шугамын сагс	62
Хавсралт Б. Статистик нэмэлт үр дүнгүүд	64
Хавсралт В. Ядуурлын тооцоонуудын стандарт алдаа ба итгэмжлэх интервал	101

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТАШН	Түүвэрлэлтийн анхан шатны нэгж
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАЧП	Худалдан авах чадварын паритет
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЯШ	Ядуурлын шугам

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 1	Ядуурлыг тооцох үйл явц	20
Зураг 1. 2	Хэрэглээний бүрэлдэхүүн	21
Зураг 1. 3	ӨНЭЗС-ны 2022 оны мэдээлэлд бодит түрээс, өөрийн тайлагнасан түрээс, сууцны үнэлгээ, орон сууцны төрлөөр	27
Зураг 1. 4	Сууцны төрөл, өгөгдлийн боломжид суурилан ӨНЭЗС-наас түрээсийн төлбөрийг тооцсон аргачлал	29
Зураг 1. 5	Өрхийн сарын дундаж хэрэглээний бүтэц	30
Зураг 1. 6	Монгол Улсын ядуурлын шугамыг олон улстай харьцуулсан байдал	35
Зураг 2. 1	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, улсын дундаж, хот, хөдөөгөөр, 2022	37
Зураг 2. 2	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, суурьшлаар, хувиар, 2022	38
Зураг 2. 3	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, бүсээр, хувиар, 2022	39
Зураг 2. 4	Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2022	40
Зураг 2. 5	Ядуурлын хамралтын хүрээ, 2017 оны ХАЧП-аар тооцсон 6.85 ам.долларын ядуурлын шугамаар, Жини коэффициент	42
Зураг 3. 1	Жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, хэрэглээний тархалт, тэнцүү 5-н бүлгээр, 2022	44
Зураг 3. 2	Жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, хэрэглээний үндсэн бүрэлдэхүүний бүтцээр, 2022	45
Зураг 3. 3	Өрхийн сарын дундаж хүнсний хэрэглээ, хүнсний хэрэглээний бүтэц, ядуурлын байдлаар, 2022	46
Зураг 3. 4	Өрхийн сарын дундаж хүнсний бус хэрэглээ, хүнсний бус хэрэглээний бүтэц, ядуурлын байдлаар, 2022	47
Зураг 3. 5	Өрхийн ам бүлийн дундаж тоо, хүн ам зүйн ачаалал, 2022	48
Зураг 3. 6	Ядуурлын хамралтын хүрээ, насны бүлэг, хүүхдийн тоогоор, 2022	49
Зураг 3. 7	25, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, ядуурлын хамралтын хүрээ, 2022	50
Зураг 3. 8	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, бага сургуулийн төрлөөр, хувиар, 2022	51
Зураг 3. 9	Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар, 2022	52
Зураг 3. 10	Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, 2022	53
Зураг 3. 11	Хөдөлмөрийн насны ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажил мэргэжил, 2022	54
Зураг 3. 12	Цалин хөлстэй ажиллагчдын жилийн дундаж цалин хөлсний орлого, сая төгрөгөөр, 2022	55
Зураг 3. 13	Өрхийн удаан эдэлгээтэй хөрөнгө, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, хувиар, 2022	56
Зураг 3. 14	Өрхийн гар утас, компьютер, интернэтийн хүртээмж, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, хувиар, 2022	57
Зураг 3. 15	Зээлтэй өрхийн эзлэх хувь, зээлийн төрлөөр, 2022	58
Зураг 3. 16	Сууцны төрөл (нийт хүн амын эзлэх хувь), хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2022	59
Зураг 3. 17	Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж, хүн амд эзлэх хувиар, 2022	60

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1	Хэрэглээний агрегатаас хассан хүнсний бус зарлага	24
Хүснэгт 1. 2	2022 оны ядуурлын шугам, жишсэн насанд хүрсэн нэг хүнээр тооцсон төгрөг	34
Хүснэгт 2. 1	Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, 2022	41

ХАВСРАЛТ Б.

СТАТИСТИКИЙН НЭМЭЛТ ХҮСНЭГТ

Хүснэгт Б. 1	Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2022	64
Хүснэгт Б. 2	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр, 2022	64
Хүснэгт Б. 3	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар, 2022	65
Хүснэгт Б. 4	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар, 2022	65
Хүснэгт Б. 5	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн ам бүлийн тоогоор, 2022	66
Хүснэгт Б. 6	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар, 2022	66
Хүснэгт Б. 7	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2022	67
Хүснэгт Б. 8	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр, 2022	67
Хүснэгт Б. 9	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар, 2022	68
Хүснэгт Б. 10	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн салбараар, 2022	68
Хүснэгт Б. 11	Мал аж ахуй эрхлэлт, 2022	69
Хүснэгт Б. 12	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар, 2022	70
Хүснэгт Б. 13	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, газар эзэмшил, өмчлөлийн байдлаар, 2022	70
Хүснэгт Б. 14	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламжийн байдлаар, 2022	71
Хүснэгт Б. 15	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, зээлийн төрлөөр, 2022	71
Хүснэгт Б. 16	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр, 2022	72
Хүснэгт Б. 17	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр, 2022	72
Хүснэгт Б. 18	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр, хот, хөдөөгөөр, 2022	73
Хүснэгт Б. 19	Шилжүүлэг, бэлэг, тусламж, төрлөөр	74
Хүснэгт Б. 20	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын болон хувийн шилжүүлэг, бэлэг, тусламжаар	75
Хүснэгт Б. 21	Жишсэн насанд хүрсэн хүнд ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, төгрөгөөр, дүнд эзлэх хувиар	76
Хүснэгт Б. 22	Жишсэн насанд хүрсэн хүнд ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, ядуурлын байдлаар, хот, хөдөөгөөр	77
Хүснэгт Б. 23	Жишсэн насанд хүрсэн хүнд ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, ядуурлын байдлаар, суурьшлаар	78
Хүснэгт Б. 24	Жишсэн насанд хүрсэн хүнд ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, ядуурлын байдлаар, бүсээр	79

Хүснэгт Б. 25	Жишсэн насанд хүрсэн хүнд ногдох хэрэглээ, төгрөгөөр, хүн амын хэрэглээний тэнцүү 10 бүлгээр	80
Хүснэгт Б. 26	Нийт хэрэглээнд эзлэх хувь, хүн амын хэрэглээний тэнцүү 10 бүлгээр	80
Хүснэгт Б. 27	Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, хот, хөдөөгөөр, хувиар	81
Хүснэгт Б. 28	Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, хот, хөдөөгөөр, хувиар	82
Хүснэгт Б. 29	Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, суурьшлаар, хувиар	83
Хүснэгт Б. 30	Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, бүсээр, хувиар	84
Хүснэгт Б. 31	18, түүнээс дээш насны хүн амын боловсролын дээд түвшин, хувиар	85
Хүснэгт Б. 32	18, түүнээс дээш насны хүн амын боловсролын дээд түвшин, хувиар	86
Хүснэгт Б. 33	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургуульд хамрагдалтын түвшин, хувиар	87
Хүснэгт Б. 34	Хүн амын өвчлөл, гэмтэл, хувиар	88
Хүснэгт Б. 35	Хүн амын өвчлөл, гэмтэл, хот, хөдөөгөөр, ядуурлын байдлаар, хувиар	89
Хүснэгт Б. 36	Хүн амын өвчлөл, гэмтэл, хүйсээр, ядуурлын байдлаар, хувиар	90
Хүснэгт Б. 37	18, түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хувиар	91
Хүснэгт Б. 38	18, түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хот, хөдөөгөөр, ядуурлын байдлаар, хувиар	91
Хүснэгт Б. 39	18, түүнээс дээш настай хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хүйсээр, ядуурлын байдлаар, хувиар	91
Хүснэгт Б. 40	Хүн ам, ажиллах хүчний байдлаар, хувиар	92
Хүснэгт Б. 41	Ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин, ядуурлын байдлаар, хувиар	93
Хүснэгт Б. 42	Ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин, хүйсээр, хувиар	94
Хүснэгт Б. 43	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, ядуурлын байдлаар, хувиар	95
Хүснэгт Б. 44	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, ядуурлын байдлаар, хувиар	96
Хүснэгт Б. 45	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, хүйсээр, хувиар	97
Хүснэгт Б. 46	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, мэргэжлээр, хүйсээр, хувиар	98
Хүснэгт Б. 47	Сүүлийн 12 сард авсан зээлийн дундаж хэмжээ, төрлөөр, мянган төгрөгөөр	99
Хүснэгт Б. 48	Зээлийн зарцуулалт, зориулалтаар, хувиар	100
Хүснэгт Б. 49	Өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээтэй бараа, хувиар	100

ХАВСРАЛТ В. ЯДУУРЛЫН ТООЦООНУУДЫН СТАНДАРТ АЛДАА БА ИТГЭМЖЛЭЛТ ИНТЕРВАЛУУД

Хүснэгт В. 1	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хот, хөдөөгөөр	101
Хүснэгт В. 2	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар	102
Хүснэгт В. 3	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр	102
Хүснэгт В. 4	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар	103
Хүснэгт В. 5	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар	103
Хүснэгт В. 6	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр	104
Хүснэгт В. 7	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр	105
Хүснэгт В. 8	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламжийн байдлаар	106
Хүснэгт В. 9	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, зээлийн байдлаар	107
Хүснэгт В. 10	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр	108
Хүснэгт В. 11	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сайжруулсан ундны усны эх үүсвэртэй эсэхээр	109
Хүснэгт В. 12	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эсэхээр	110
Хүснэгт В. 13	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, цахилгаан эрчим хүчний хангамжтай эсэхээр	111
Хүснэгт В. 14	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, цахилгаан эрчим хүчний хангамж, сайжруулсан ундны усны эх үүсвэр болон сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эсэхээр	112

ХУРААНГУЙ

Энэхүү тайланд 2022 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-нд үндэслэн ядуурлын чиг хандлага, өрхийн аж байдал, хүн амын бүлгүүдийн тэгш бус байдлын талаар хийсэн дүн шинжилгээ болон ядуурлыг хэмжих шинэчилсэн аргачлалыг тусгаж өгсөн.

ЯДУУРЛЫН ТООЦООНЫ АРГА ЗҮЙГ ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГАД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧИЛЛЭЭ.

Монгол Улсын ядуурлыг хэмжих 2022 оны аргачлалд ядуурлын тооцооллын нарийвчлал болон харьцуулах байдлыг сайжруулахад чиглэсэн дараах гол өөрчлөлтийг хийлээ. Нэгдүгээрт, Дэлхийн Банкнаас (Манчини, Векчи, 2022) олон улсын сайн туршлагад үндэслэн боловсруулсан ядуурал, тэгш бус байдлыг хэмжих, хэрэглээний иж бүрдлийг байгуулах гарын авлагын зөвлөмжийг тусгав. Хоёрдугаарт, ядуурлын шугамыг 2010 оноос хойшхи хүн амын амьжиргаа, хэрэглээний хэв маягт гарч буй өөрчлөлтийг тусган шинэчилсэн. Гуравдугаарт, өрхийн хэрэглээг илүү нарийвчлан хэмжихийн тул ядуурлын тооцооллын мэдээллийн эх үүсвэр болох Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны асуулгад өөрчлөлт оруулав.

Ядуурлын 2022 оны тооцооллын арга зүйд оруулсан гол шинэчлэл:

- **ӨНЭЗС-ны хэрэглээний мэдээлэл сайжирсан.** ӨНЭЗС-ны 2022 оны асуулга, мэдээлэл цуглуулах аргыг сайжруулж, хүнс, хүнсний бус болон удаан эдэлгээтэй барааны хэрэглээний мэдээллийн нарийвчлалыг нэмэгдүүлсэн.
- **Хэрэглээний иж бүрдэл, бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээний загварыг сайжруулсан.** Хэрэглээний иж бүрдэл байгуулах тооцооллыг шинэчилсэн. Мөн олон улсын сайн туршлагад үндэслэн

сууцны түрээс, удаан эдэлгээтэй барааны үнэлгээний загварыг сайжруулсан.

- **Нэг хүнд ногдох хэмжээс ашиглаж байсныг жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох хэмжээст шилжүүлсэн.** Энэхүү тохируулга нь өрхийн эдийн засгийн чадамж болон өрхийн гишүүдийн наснаас хамаарсан хэрэглээний ялгааг тооцоолох замаар өрхийн бодит хэрэглээг илүү нарийвчлалтай үр дүн гаргах боломжийг олгодог. Монгол улс шиг дундын бараа бүтээгдэхүүн болох хүнсний бус хэрэглээ өндөртэй орнууд жишсэн насанд хүрсэн хүний хэрэглээг ашиглахыг олон улсад зөвлөмж болгодог.
- **Бүс нутгийн ялгааг тодорхойлохын тулд үнийн тохируулгыг сайжруулсан.** Монгол Улсад өрхийн хүнсний бус хэрэглээ өндөр байгааг харгалзан үнийн тохируулгыг хийхдээ хүнсний бүтээгдэхүүнээс гадна хүнсний бус бараа, бүтээгдэхүүнийг хамруулсан.
- **Амьжиргааны хэв шинжид гарч буй өөрчлөлтийг тусган ядуурлын шугамыг шинэчилсэн.** Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон Дэлхийн банк хамтран ядуурлын шугамыг арван жилийн давтамжтай шинэчлэх олон улсын зөвлөмжийн дагуу Монгол Улсын ядуурлын шугамыг шинэчилсэн. Ядуурлын шугамыг тодорхойлоход ашигладаг бараа, үйлчилгээний сагсыг өрхийн хэрэгцээ болон хэрэглээний хэв маягийн өөрчлөлтөд нийцүүлэн аргачлалд тусгасан. Түүнчлэн Монгол Улсын хүн амын хүнсний бус зардал харьцангуй өндөр байгааг харгалзан хүнсний бус зардлын бүрэлдэхүүний тооцооллыг сайжруулсан.

ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ХҮН АМЫН ЯДУУРЛЫН ТҮВШИН ӨНДӨР БАЙГАА ХЭДИЙ Ч ЯДУУРЛЫН ШУГАМААС БАГА ХЭРЭГЛЭЭТЭЙ ХҮН АМЫН ДИЙЛЭНХ НЬ ХОТ СУУРИН ГАЗАРТ АМЬДАРЧ БАЙНА.

Ядуурлын түвшин 2022 онд 27.1 хувь болж, 913.7 мянган хүн ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байна. Үндэсний ядуурлын шугам 2022 оны байдлаар 418,045 төгрөг байна. Жишсэн насанд хүрсэн нэг хүний сарын хэрэглээ энэ ядуурлын шугамаас бага бол ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн гэж тооцно.

Ядуурлын түвшин хөдөө орон нутагт харьцангуй өндөр байна. Хөдөө орон нутгийн хүн амын 35.5 хувь нь ядуурлын шугамаас бага хэрэглээтэй байгаа бол хот суурин газарт 23.0 хувь байна. Суурьшлаар нь авч үзвэл, хөдөөгийн ядуурлын түвшин хамгийн өндөр буюу 41.2 хувьд хүрсэн нь сумын төвөөс 10.6 нэгж хувиар, аймгийн төвөөс 15.1 нэгж хувиар, Улаанбаатар хотоос 19.6 нэгж хувиар өндөр байна. Хөдөө орон нутгийн өрхүүд хотын өрхүүдтэй харьцуулахад илүү санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байгаа нь цаашид ч хэрэглээ нь багасаж, амьжиргаа нь муудах эрсдэлд байна.

Хөдөөд ядуурлын түвшин өндөр байгаа хэдий ч ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын дийлэнх буюу 56.8 хувь нь хот, суурин газарт амьдарч байна. Энэ нь хот суурин газрын хүн амын төвлөрөл, ялангуяа Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл их байдагтай холбоотой. Хот суурин газрын энэ төвлөрөл хүн амын орон сууцны нөхцлийг сайжруулах, суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн эмзэг байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

ТЭГШ БУС БАЙДАЛ БОЛОН ЭМЗЭГ БАЙДАЛ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАЖ, ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТИЙГ СААРУУЛЖ БАЙНА.

Хүн амын нэлээдгүй хувийн хэрэглээ ядуурлын шугамаас бага зэрэг дээгүүр

байгаа нь тэднийг санхүү, эдийн засгийн ямар нэг цочролд маш эмзэг байгааг харуулж байна. Ядуурлын шугамыг 20 хувиар өсгөхөд нийт хүн амын 13.9 хувь буюу 468.0 мянган хүн ядууралд нэмж өртөхөөр байгаа бөгөөд ажилгүй болох, өвдөх, байгалийн гамшигт өртөх гэх мэт гэнэтийн цочрол нь тэднийг ядуурал руу түлхэж болзошгүй байна. Эмзэг байдлын түвшин өндөр байгаа нь ядуурлын шугамаас бага хэрэглээтэй хүн ам болон ямар нэг гэнэтийн цочрол тохиолдоход ядууралд өртөх эрсдэлтэй хүн амыг хоёуланг нь дэмжих бодлого хэрэгтэйг онцолж байна.

Хэдийгээр Монгол Улс дахь тэгш бус байдал бус нутгийн бусад орнуудаас доогуур байгаа ч энэ нь байнгын сорилт хэвээр байна. Хүн амын хамгийн чинээлэг 20 хувь нь нийт хэрэглээний 40 шахам хувийг бүрдүүлдэг бол хамгийн ядуу 20 хувь нь ердөө 8 хувийг бүрдүүлдэг. Тэгш бус байдал ялангуяа хот суурин газарт илүү ажиглагдаж байгаа бөгөөд Жини индексийг авч үзвэл хөдөө орон нутгаас 6.4 нэгж хувиар өндөр байна. Хэдийгээр Улаанбаатар хотод ядуурлын түвшин харьцангуй бага ч улсын хэмжээнд тэгш бус байдлаараа хамгийн өндөр буюу Жини индекс 33.2 байна.

Өрхүүд хэрэглээний 70 орчим хувийг хүнсний бус бараа, үйлчилгээнд зарцуулж байгаа нь манай улсын хувьд хүнсний бус хэрэглээ өндөртэй байгааг харуулж байна. Хүн амын амьжиргааны бүлэг хооронд хэрэглээг харьцуулж авч үзвэл сууц болон удаан эдэлгээтэй барааны хэрэглээний ялгаа илүү өндөр байна. Тухайлбал, хамгийн чинээлэг 20 хувийнхан удаан эдэлгээтэй бараа болон сууцны хэрэглээнд хамгийн ядуу бүлгийнхээс дунджаар 11 дахин их зардал гаргадаг байна. Ядуу өрхүүдийн хувьд нийт хэрэглээнийхээ ихэнх хувийг хоол хүнс, эрчим хүч, дулаанд зарцуулдаг бол чинээлэг өрхүүд боловсрол, эрүүл мэнд, удаан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүнд ихээхэн хөрөнгө оруулалт хийж, энэ нь цаашид бий болох тэгш бус байдлыг улам нэмэгдүүлж байна. Хотын ядуу өрхүүд эрчим хүчинд, харин хөдөөгийн ядуу өрхүүд хувцас, унааны зардалд илүү их зардал гаргадаг байна. Иймд хот болон

хөдөөгийн ядуу хүн амд ялгаатай бодлогыг авч хэрэгжүүлэх хэрэгцээ байгааг харуулж байна.

ӨРХИЙН АМ БҮЛИЙН ТОО БОЛОН ӨРХӨД ТЭЖЭЭЛГЭГЧДИЙН ТОО ОЛОН БАЙХ НЬ ЯДУУРАЛД ӨРТӨХӨД ИЛҮҮ НӨЛӨӨЛЖ БАЙНА.

Ядуу өрхүүд ихэвчлэн ам бүл олон бөгөөд илүү олон тэжээлгэгчтэй байдаг нь тэднийг ядууралд өртөмтгий болгож байна. 2022 онд ядуу өрх дунджаар 4.2 гишүүнтэй байсан бол ядуу бус өрхүүдийн ам бүлийн дундаж 3.2 байна. Мөн хамгийн ядуу 20 хувь нь чинээлэг 20 хувиас 1.5 дахин илүү ам бүлтэй байна. Энэ нь ядуу өрхүүд илүү олон хүүхэдтэй байдагтай холбоотой. Өрхийн ам бүлийн тоо их байх нь санхүүгийн дарамтыг нэмэгдүүлж, үндсэн хэрэгцээгээ хангах, боловсрол, эрүүл мэнд болон бусад чухал үйлчилгээнд хөрөнгө оруулахад хүндрэл учруулдаг.

Хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээлгэгчдийн тоо болон хүүхдийн тоо ихсэх тусам ядуурал нэмэгдэж байна. Ядуу өрхийн хүн ам зүйн ачаалал дунджаар ядуу бус өрхийнхөөс 22.6 хувиар өндөр буюу ядуу өрхийн хөдөлмөрийн насны 100 хүнд ядуу бус өрхтэй харьцуулахад 14 тэжээлгэгч илүү ногдож байна. Энэ нь нэг хүнд ногдох орлогыг бууруулж, бага орлоготой хүмүүс илүү олон хүмүүсийг тэжээн тэтгэх ёстой болсноор эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. 15 нас хүртэлх хүүхдүүдийн 31-33 хувь нь ядуу амьдарч байгаа нь улсын дунджаас 4-6 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм. Энэ нь хүүхдүүд ядуурлын өндөр эрсдэлд байгааг илтгэж байна.

БОЛОВСРОЛ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЯЛГАА НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫГ ГҮНЗГИЙРҮҮЛЖ, ЯДУУРЛЫН ЭРСДЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА.

Боловсролын хязгаарлагдмал байдал нь ядуурлын эрсдэлийг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг, учир нь ядуу хүмүүс ихэвчлэн ур чадвар бага шаардсан, бага цалинтай ажилд ажиллах магадлал өндөр байдаг. Ядуу болон ядуу бус хүмүүсийн хооронд

боловсролын ялгаа ихтэй, ялангуяа дээд боловсролын түвшинд илүү ажиглагддаг. Ядуу 25, түүнээс дээш насны хүн амын зөвхөн 10 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байдаг бол ядуу бус хүн амын 39 хувь байна. Боловсролгүй хүн амын хувьд ядуурлын түвшин хамгийн өндөр буюу 51 хувьтай байгаа бол дээд боловсролтой хүн амын 7 хувь нь ядуу байна. Иймд боловсрол болон ядуурлын хамаарал нь бүх түвшинд чанартай боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгтэйг онцолж байна.

Ядуу өрхийн хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд (СӨБ)-д хамрагдах магадлал багатай байгаа нь хүн амын ялгаатай байдал бага наснаасаа эхэлж байгааг харуулж байна. Хамгийн чинээлэг бүлгийн хүн амын 2-6 настай хүүхдүүдийн 63 хувь нь СӨБ-д хамрагдаж байгаа бол хамгийн ядуу бүлгийнхний хувьд энэ үзүүлэлт 45 хувьтай байна. Мөн алслагдсан хөдөө орон нутгийн хүүхдүүд боловсролын байгууллага тэдний амьдарч буй газраас хол зайд байгаагаас шалтгаалан сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж хязгаарлагдмал байсаар, энэ нь урт хугацаандаа сул тал болж байна. Цаашлаад ядуу хүн амын хүүхдүүд ихэвчлэн төрийн сургуульд суралцдаг бол чинээлэг өрхүүд хувийн сургуулийг сонгох хандлага нэмэгдэж, энэ нь ирээдүйд боловсрол болон эдийн засгийн хувьд тэгш бус байдлыг бий болгох шалтгаан болж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байдал нь хүн амын ядуурал, амьжиргааг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. 2022 онд ядуу хүн ам ядуу бус хүн амтай харьцуулахад хөдөлмөр эрхлэх магадлал 10.1 нэгж хувиар бага байсан. Тэгвэл хотод энэ зөрүү 14.8 нэгж хувьтай байгаа нь хотын ядуу иргэд ажил олох, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэхэд илүү их бэрхшээлтэй тулгарч байгааг илтгэж байна. Мөн чинээлэг бүлгийн ажилчид мэргэжлийн болон удирдах албан тушаалд илүү ажилладаг бол ядуу ажилчид хөдөө аж ахуйн салбарт эсвэл өрхийн бизнесийн үйл ажиллагаанд цалин хөлсгүй ажил эрхлэх зэргээр ур чадвар бага шаардсан, албан бус салбарт хөдөлмөр эрхэлдэг. Цаашлаад ядуу

болон ядуу бус ажиллагчдын цалингийн ялгаа мэдэгдэхүйц өндөр байна. Тухайлбал, ядуу ажилчдын цалингийн орлого ядуу бус ажилчдын авдаг цалингийн бараг талтай тэнцүү байна. Түүнчлэн, боловсролын түвшин, ажил мэргэжил, ажил эрхэлж буй салбар ижил хэдий ч ядуу хүмүүсийн хувьд орлого олох болон албан тушаал ахих боломжийг нь хязгаарладаг бүтцийн саад бэрхшээлтэй байсаар байна. Энэ нь чанартай ажлын байр, мэргэжлийн сургалт, цалин хөлсний зөв бодлогын хэрэгцээ байгааг онцлон харуулж байна.

САНХҮҮГИЙН БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ӨМЧЛӨЛИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАЖ БАЙНА.

Ядуу өрхүүдэд санхүүгийн боломжийг нэмэгдүүлэх хөрөнгө бага байгаа нь тэдний санхүүгийн тогтвортой байдлыг бий болгох, орлого олох болон урт хугацааны баялаг хуримтлуулах боломжийг хязгаарладаг. Өрхүүдэд өргөн хэрэглээний, жишээлбэл хөргөгч болон өнгөт зурагт зэрэг гэр ахуйн эд хогшилтой байх хандлага түгээмэл байдаг хэдий ч бүтээмжийг нэмэгдүүлдэг автомашин эсвэл угаалын машин зэрэг цахилгаан хэрэгсэл эзэмшдэг байх нь амьжиргааны бүлгүүд хооронд ялгаатай байна. Тухайлбал, хамгийн чинээлэг бүлгийн өрхүүд хамгийн ядуу бүлгийнхтэй харьцуулахад суудлын машинтай байх магадлал дөрөв дахин их байна.

Алслагдсан хөдөө нутагт амьдардаг иргэд болон ядуу хүмүүст технологи ашиглах боломж хязгаарлагдмал, цаашлаад технологиор дамжуулан мэдээлэл олж авах, эдийн засаг, боловсролоо дээшлүүлэх боломж бага байна. Гар утас эзэмших байдал хүн амын дунд элбэг байдаг ч амьжиргааны бүлгийн хувьд авч үзвэл гар утас эзэмшдэг хамгийн ядуу бүлгийн хүн ам хамгийн чинээлэг бүлгийнхээс 14 нэгж хувиар бага байна. Мөн хамгийн ядуу бүлгийн өрхийн дөнгөж хоёр хувь нь компьютертой, дөрвөн өрх тутмын нэг нь интернэтэд холбогдсон байдаг бол чинээлэг бүлгийн өрхүүдийн

арван хүн тутмын бараг найм нь интернэтэд холбогдсон байна. Энэ ялгаатай байдал нь алслагдсан хөдөө нутагт цахим дэд бүтэц хязгаарлагдмал, холболт сул, төхөөрөмжүүд өрхүүдийн орлоготой харьцуулахад үнэтэй байдагтай холбоотой байж болох юм.

Ядуу өрхүүд ихэнхдээ найдвартай эрчим хүчний эх үүсвэрээр хангагдах боломж хязгаарлагдмал сууцанд амьдарч байна. Хот, хөдөөгийн аль алинд нь ядуу өрхүүдийн дийлэнх нь гэрт амьдарч байна. Тухайлбал, хотын хамгийн ядуу бүлгийн арван өрх тутмын зургаа нь гэрт амьдардаг бол хамгийн чинээлэг бүлгийн нэг хувь нь гэрт амьдардаг. Гэрт найдвартай эрчим хүчний эх үүсвэр, ариун цэврийн байгууламжид холбогдох хязгаарлагдмал тул өрхүүд халаалтаа зуухаар шийдэхээс өөр аргагүйд хүрдэг. Энэ нь өртөг өндөртэй байхаас гадна эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй байдаг. Судалгааны үр дүнгээс харахад 2022 онд ядуу арван хүн тутмын ес нь дэд бүтцийн суурь үйлчилгээний аль нэгийг (сайжруулсан ундны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламж, дулааны байнгын эх үүсвэр) авах боломжгүй байна.



БҮЛЭГ:

1



ЯДУУРЛЫГ ХЭМЖИХ ШИНЭЧИЛСЭН АРГАЧЛАЛ

ЯДУУРЛЫГ ХЭМЖИХ НЬ	17
2022 ОНЫ ЯДУУРЛЫН ТООЦООЛОЛ	18
1 Хэрэглээ (нэрлэсэн)-г бүрдүүлэх нь	18
2 Хэрэглээний тохируулга	27
3 Ядуурлын шугамыг шинэчлэх нь	29

ЯДУУРЛЫГ ХЭМЖИХ НЬ

Энэхүү тайланд 2022 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг (ӨНЭЗС) ашиглан мөнгөн хэлбэрээр ядуурлыг тооцох шинэчилсэн аргачлалыг дэлгэрэнгүй байдлаар танилцуулна. Арга зүйн шинэчлэл болон ядуурлын шугамыг шинэчлэхэд Манчини болон Векчи (2022) нарын олон улсын сайн туршлагад үндэслэн боловсруулсан Дэлхийн банкны шинэчилсэн гарын авлагыг ашиглав.

Ядуурлыг ойлгох нь

Хувь хүн, айл өрх үндсэн хэрэгцээгээ хангаж, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байх олон талт үзэгдлийг ядуурал гэнэ. Ядуурлыг орлого, хэрэглээгээр нь дамжуулан үнэлэх нь нийтлэг. Гэвч ядууралд мөнгөөр илэрхийлэгдэхгүй ойлголтууд ч мөн хамаарна. Тухайлбал, энд нийгмээс ялгаварлан гадуурхагдах, чухал шаардлагатай үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх зэргийг дурдаж болох юм. Монгол Улсын хувьд ядуурлыг өрхийн хэрэглээнд суурилсан улсын хэмжээний ядуурлын түвшнээр тодорхойлж байна.

Ядуурлыг хэмжих нь

Мөнгөн хэмжүүрээр ядуурлыг хэмжихдээ дараах гурван үе шат бүхий системчилсэн аргыг хэрэглэдэг. Үүнд:

- 1. Аж байдлыг хэмжих үзүүлэлтийг тодорхойлох:** Аж байдлын үзүүлэлт нь хувь хүн, өрхийн эдийн засгийн төлөв байдлыг мөнгөн дүнгээр илэрхийлнэ. Үүнд; өрхийн хэрэглээ, өрхийн орлого зэргийг дурдаж болно.
- 2. Ядуурлын шугамыг тогтоох:** Ядуурлын шугам нь хувь хүн, өрхийн аж ахуйд наад захын хэрэгцээгээ хангахад шаардлагатай нөөцийн хамгийн бага хэмжээ байна. Ядуурлын шугамыг тогтоохдоо нэг бол амьжиргаанд зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүний сагсанд тулгуурлах, эсвэл арай өргөн хүрээтэй амьжиргааны нийт

өртгийг тусгасан стандартад суурилж болно.

- 3. Ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох:** Хүн амын ядуурлыг хэмжихэд ядуурлын түвшин, ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмж зэрэг үзүүлэлтийг ашиглана.

Аж байдлын үзүүлэлтийн сонголт

Ядуурлыг хэмжихдээ орлого, хэрэглээ хоёрын алийг нь ашиглах вэ? гэсэн асуулт маргаан дагуулдаг. Орлого гэдэгт хувь хүн, айл өрхийн цалин, шилжүүлэг болон бусад эх үүсвэрээс олсон мөнгөн орлогыг хэлнэ. Гэвч хөгжиж буй улс орнуудад орлогыг хэмжих нь тэр болгон амар зүйл биш төдийгүй улирлын чанартай ажил эсвэл эдийн засгийн гэнэтийн цочролоос хамааран орлого хэлбэлзэх нь түгээмэл юм. Харин орлоготой харьцуулахад өрхийн хэрэглээ (бараа, үйлчилгээ) нь өрхийн аж байдлыг илүү бодитой, үнэн зөв хэмждэг гэж үздэг. Өрхийн хэрэглээ нь амьжиргааны түвшинг илүү бодитой илэрхийлж, тэр болгон их хэлбэлздэггүй. Айл өрхүүд орлого буурах үед зээл авах, хуримтлалаа ашиглах замаар хэрэглээний дутуугаа нөхнө. Тогтмол орлогын таамаглал (Permanent Income Hypothesis)-д айл өрхүүд зардлын шийдвэрээ насан туршийн хүлээгдэж буй орлогод үндэслэн (богино хугацаанд хэлбэлзэж буй орлогод бус) гаргадаг тул урт хугацааны аж байдлыг хэрэглээгээр нь дамжуулан үнэлэх нь зохимжтой гэж үздэг. Хөгжиж буй олон улс орон, үүний дотор Монгол ч гэсэн ядуурлыг хэмжихдээ хэрэглээг ашигладаг байна.

2022 ОНЫ ЯДУУРЛЫН ТООЦООЛОЛ

Энэ хэсэгт 2022 оны ӨНЭЗС-ны мэдээллийг ашиглан тооцсон ядуурлын аргачлалыг авч үзье (Зураг 1.1). Нэгдүгээрт, хэрэглээний бүрэлдэхүүнийг нэрлэсэн дүнгээр тооцоолно. Хоёрдугаарт, өрхийн бүтэц, ам бүлийн тоо

болон амьжиргааны өртгийн ялгавартай байдлыг харгалзан үзэж аж байдлын үзүүлэлтэд тохируулга хийнэ. Гуравдугаарт, ядуурлын шугамыг тооцож, эцэст нь ядуурлын үзүүлэлтүүдийг тооцно.

Зураг 1.1 Ядуурлыг тооцох үйл явц



1. ХЭРЭГЛЭЭ (НЭРЛЭСЭН)-Г БҮРДҮҮЛЭХ НЬ

Т Ядуурлыг хэмжихдээ эхлээд хэрэглээг нэрлэсэн дүнгээр тооцоолох ба энэ нь хамгийн чухал үе шат юм. Хэрэглээ нь айл өрхүүдийг эдийн засгийн аж байдлаар нь эрэмбэлэх боломж олгоно. Ядуурлыг тодорхойлох хэрэглээний бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд дараах дөрвөн шалгуур хангагдах ёстой (Манчини болон Векчи, 2022). Үүнд;

1. Цогц байх: Хэрэглээнд нь хэрэглэсэн бүх бараа, үйлчилгээг хамруулна. Үүнд; мөнгөн зарлага, биет орлогын хэрэглээ (тухайлбал, гэртээ хийсэн хоол хүнс),

өмчлөгч өөрөө оршин сууж буй орон сууцны үнэ зэрэг хамаарна.

2. Хамааралтай байх: Хэрэглээнд зарлага биш зөвхөн хэрэглэсэн бараа, үйлчилгээг хамруулна. Тухайлбал, худалдан авсан бараа, үйлчилгээг зөвхөн хэрэглэсэн тохиолдолд л хамруулна гэсэн зарчим баримтална. Харин удаан эдэлгээтэй барааны хувьд тухайн хугацааны туршид ашиглагдсан өртгийг авч үзэх ба анх худалдаж авсан үнэ, өртөг нь хамаарахгүй. Энд зээлийн эргэн төлөлт, хадгаламж зэрэг хэрэглээний бус гүйлгээг мөн хамруулахгүй.

3. Хэрэглээ нь нийтлэг байх: Хэрэглээнд тогтмол биш эсвэл их хэмжээний зардал гаргасан хэрэглээг оруулахгүй. Харин нийтлэг, урт хугацааны хэрэглээг хамруулна. Тухайлбал, хурим найр, оршуулгын ажил явдалтай холбоотой нэг удаагийн их хэмжээний зардлыг хамруулахгүй. Ийм зардал нь өрхийн өдөр тутмын зардлыг илэрхийлэхгүй.

4. Мөнгөн хэмжигдэхүүнд шилжүүлэх боломжтой байх: Хэрэглээг мөнгөн

хэмжигдэхүүнд шилжүүлж зах зээлийн үнээр илэрхийлнэ. Харин зах зээлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд (татаастай эсвэл өөрсдөө үйлдвэрлэсэн) тохирсон үнийг олж тогтооно.

Хэрэглээ нь 1) хүнсний хэрэглээ, 2) хүнсний бус зардал (удаан бус эдэлгээтэй), 3) удаан эдэлгээтэй барааны бий болгосон хэрэглээний урсгал, 4) орон сууцны хэрэглээ гэсэн дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ (Зураг 1.2).

Зураг 1. 2 Хэрэглээний бүрэлдэхүүн



1.1 Хүнсний хэрэглээ

Хүнсний хэрэглээний мэдээлэл

ӨНЭЗС-гаар 2022 онд өрхийн гишүүдийн сүүлийн 7 хоногийн хүнсний хэрэглээг үнэ болон хэмжээний хамт нэг бүрчлэн дэлгэрэнгүй цуглуулсан. Хотын өрхүүд 7 хоногийн өдрийн тэмдэглэл хөтөлж хэрэглээгээ бүртгэдэг бол хөдөөгийн өрхүүд 7 хоногийн хэрэглээгээ санаж мэдээлэл цуглуулагчид мэдээлдэг. Судалгаа нь худалдан авсан, бусдаас үнэгүй авсан, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн, гэрээс гадуур

хэрэглэсэн зэрэг бүхий л хүнсний хэрэглээг хамарна. Хэрэглээнд гэртээ хэрэглэсэн 121 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, гэрээс гадуурх хэрэглэсэн 7 төрлийн хүнсний бүтээгдэхүүн (хоол, хөнгөн зууш, ундаа, бэлэн хоол хүнс) зэрэг багтсан. Тамхи, согтууруулах ундааны мэдээллийг хүнсний бүлэгт цуглуулдаг ч хүнсний хэрэглээ болж, бие махбодийг шим тэжээлээр хангахгүй тул хүнсний хэрэглээнд хамааруулаагүй болно. Хэрэглээний цогц байх шалгуурын дагуу тамхи, согтууруулах ундаа хүнсний бус хэрэглээнд оруулсан.

Тооцох арга зүй

Өрхийн хүнсний хэрэглээ нь гэртээ хэрэглэсэн болон гэрээс гадуур хэрэглэсэн хоол хүнс гэсэн үндсэн хоёр бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Гэртээ хэрэглэсэн хүнс нь худалдан авсан, бусдаас үнэгүй авсан эсвэл гэртээ өөрсдөө үйлдвэрлэсэн хүнсийг багтаана. Гэртээ хэрэглэсэн хүнсний хэрэглээг тооцохдоо h өрх бүрийн хэрэглэсэн хүнсний i бүтээгдэхүүн тус бүрийн биет хэмжээг сүүлийн долоо хоногийн харгалзах нэгжийн үнээр үржүүлж тооцох бөгөөд уг хүнсний бүтээгдэхүүн тус бүрийн үржвэрийг нэмж, өрхийн нийт хүнсний хэрэглээг тооцно (Тэгшитгэл 1).¹ Өрхийн мэдээлсэн гэртээ

хэрэглэсэн хүнсэнд зарцуулсан зардлыг шууд авч ашиглахгүй, учир нь өрхүүд мэдээлэл цуглуулах хугацаанд худалдан авсан хүнсээ, ялангуяа багцаар нь их хэмжээгээр худалдан авсан тохиолдолд, бүгдийг хэрэглэж дуусгахгүй. Тиймээс эдгээр бүтээгдэхүүн тус бүрийг өрх бүрийн хувьд тооцож нэгтгэн жилээр тооцдог. Гэрээс гадуурх хоол хүнсний хэрэглээг тооцохдоо өрхийн мэдээлсний дагуу өрхийн гишүүдийн гэрээс гадуур хэрэглэсэн хоол хүнсний худалдан авалтын зардал дээр бусдаас үнэгүй авч хэрэглэсэн хэрэглээ (in-kind consumption)-г нэмж, өрхийн түвшинд нэгтгэн тооцно (Тэгшитгэл 2).

Тэгшитгэл

$$(1) \quad \text{Гэртээ хэрэглэсэн хүнсний хэрэглээ}_n = \frac{365}{7} \sum_{i=1}^n (\text{Тоо хэмжээ}_{ih} \times \text{Үнэ}_{ih})$$

$$(2) \quad \text{Гэрээс гадуурх хоол хүнсний хэрэглээ}_n = \frac{365}{7} \sum_{i=1}^n \left(\text{Худалдан авалтын зардал}_{ih} + \text{Бусдаас үнэгүй авч хэрэглэсэн хэрэглээ}_{ih} \right)$$

Тооцоололд өрхийн худалдан авсан хүнснээс гадна өөрийн үйлдвэрлэлийн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн хоол хүнсний хэрэглээг нэгтгэж байгаа нь цогц байх шалгуурыг хангасан. Энэ нь газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг хөгжиж буй орны хувьд чухал асуудал болно. Худалдаж авсан хоол хүнсний хувьд ӨНЭЗС-гаар өрхийн сүүлийн 30 хоногийн худалдан авалтын нэгжийн үнэ, тоо хэмжээний талаарх мэдээллийг цуглуулдаг бөгөөд энэ нь худалдан авсан хүнсний хэрэглээг үнэлэх боломжийг бүрдүүлдэг. Холимог хэрэглээтэй буюу худалдан авалтаас гадна бусдаас үнэгүй авсан эсвэл өрхийн өөрийн үйлдвэрлэлийн хүнсийг хэрэглэсэн тохиолдолд худалдан авалтын нэгжийн үнээр худалдан аваагүй бүтээгдэхүүнийг үнэлнэ. Харин зөвхөн үнэгүй авсан, эсвэл өөрийн үйлдвэрлэлийн хүнс хэрэглэсэн хэмээн мэдээлсэн айл өрхийн хувьд үнэлгээг хийхэд

тодорхой хүндрэлтэй тулгардаг.

Үнэлгээний шалгуурын дагуу бүх хэрэглээг зах зээлийн үнээр үнэлэх ёстой. Газарзүйн байршлын хувьд нэг түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-д оршин суугаа өрхүүдийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнэ харьцангуй ижил байх тул мэдээлэл байхгүй өрхүүдийн хувьд ойр хавьд байгаа өрхүүдийн нэгж үнүүдийг ашиглана. Тодруулбал, тодорхой барааны хувьд үнийг орлуулахдаа судалгааны улирал дахь тухайн газарзүйн байршилд оршин суугаа бусад өрхийн худалдан авсан ижил барааны харгалзах медиан үнээр өөрийн үйлдвэрлэлийн болон үнэгүй авч хэрэглэсэн барааг үнэлнэ. Хэрэв тухайн ТАШН-д орлуулах үнэ байхгүй тохиолдолд баг, сум, байршил, хот, хөдөөгөөр, цаашлаад улсын түвшний мэдээллээс үнийн медиан утгыг тооцож болно.² Тооцооллоос

1 Тооцоо хийхийн өмнө хэрэглэсэн бүтээгдэхүүний биет хэмжээ болон нэгж үнийн онцгой утгуудыг Хавсралтад дурдсан аргачлалын дагуу тодорхойлно

2 Үнийг аль ч түвшинд орлуулахдаа тухайн барааны хувьд ядаж 3 ажиглалт байх ёстой.

харахад нийт үнийн орлуулалтын 25 орчим хувийг ТАШН-ийн үнийн медиан утгыг ашиглаж байгаа бол 90 орчим хувь нь аймаг болон доод түвшний үнээр орлуулагдсан. Энэ нь үнийн орлуулалтад илүү орон нутгийн зах зээлийн үнэ тусгагдсан гэдгийг харуулж байна. Нийт хүнсний хэрэглээний 17 орчим хувьд үнийн орлуулга хийгдсэн байна.

1.2 Хүнсний бус хэрэглээ (удаан эдэлгээтэй бус бараа)

ӨНЭЗС-гаар 2022 онд 306 нэр төрлийн хүнсний бус бараа, бүтээгдэхүүний мэдээллийг цуглуулсан байна. Хэрэглээний олон төрлийн хэв маягийг тооцоонд тусгахын тулд өрхийн хүнсний бус хэрэглээг сүүлийн 1 сар болон сүүлийн 12 сараар хоёр ялгаатайгаар цуглуулжээ. Хүнсний бус бараа, бүтээгдэхүүний шинж чанараас хамааран судалгаагаар зөвхөн худалдан авалтын зардлыг цуглуулсан ба бүтээгдэхүүний тоо,

хэмжээг цуглуулаагүй болно.

Тооцох арга зүй

ӨНЭЗС-гаар хүнсний бус бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн мэдээллийг цуглуулаагүй тул хүнсний бус зарлагын тооцооллыг харьцангуй шууд хийх боломжтой. Өрхийн сүүлийн 1 сар болон сүүлийн 12 сарын хэрэглээнд суурилан бүтээгдэхүүн тус бүрийн хувьд жилийн зарцуулалтыг өрхийн түвшинд нэгтгэж, нийт хүнсний бус хэрэглээг тооцно (Тэгшитгэл 3). Өрхийн бүх хэрэглээг хамруулахад ийнхүү хугацаагаар ангилан цуглуулсан мэдээлэл чухал бөгөөд өөрөөр хэлбэл, тогтмол хэрэглэгддэггүй бараа, үйлчилгээний хувьд сүүлийн 12 сарын хэрэглээнд тулгуурлан тодорхойлох бол тогтмол хэрэглэгддэг бараа (эм, саван зэрэг) үйлчилгээний хувьд сүүлийн нэг сарын мэдээлэлд тулгуурлан тооцно.

Тэгшитгэл

$$(3) \text{ Хүнсний бус хэрэглээ}_h = \sum_{i=1}^n (\text{Худалдан авалтын зардал}_{ih} \times \text{Биет зарлага}_{ih})$$

Хүнсний бус хэрэглээг тооцоход хамгийн чухал зүйл бол хүнсний бус хэрэглээнд ямар бүтээгдэхүүн, үйлчилгээг оруулахыг тодорхойлох явдал юм. Хамааралтай байх, нийтлэг хэрэглээ байх гэсэн 2 шалгуураар энэ бүлгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, **хамааралтай байх шалгуур** нь тухайн хэрэглээ нь өрхийн өнөөгийн аж байдалд хувь нэмэр оруулж байна уу гэдгээр илэрхийлэгдэх ба энэ шалгуурыг хангаж байгаа бол тухайн хүнсний бус бараа, үйлчилгээг энэ бүлэгт оруулна. Жишээлбэл, санхүүгийн хөрөнгө оруулалт, хадгаламж, зээлийн төлбөрүүд нь ирээдүйн эсвэл өнгөрсөн хэрэглээг илэрхийлэх тул хасагдана. Түүнчлэн, цахилгаан бараа, компьютер, тээврийн хэрэгсэл зэрэг удаан эдэлгээтэй бараа нь өрхийн аж байдалд хувь

нэмэр оруулж байгаа хэдий ч судалгааны хамрах хугацаанаас илүү урт удаан хугацаанд ашиглагдах тул энэ бүлэгт хамрагдахгүй (удаан эдэлгээтэй барааны хэрэглээний тооцооллыг дараагийн бүлгээс харна уу).

Нийтлэг хэрэглээ байх гэсэн шалгуурын дагуу хэрэглээ нь ердийн, өдөр тутмын хэрэглээний бараа, үйлчилгээг хамрах ёстой. Өөрөөр хэлбэл, өрхийн өдөр тутмын аж байдалд хамааралгүй гэрлэлт, оршуулгын зэрэг тогтмол бус, онцгой ("том дүнтэй") зарцуулалтуудыг хасаж тооцно. Түүнчлэн, бусад өрхөд өгсөн хандив, тусламжийг давхар тооцооллоос зайлсхийхийн тулд хасна. Энэхүү хандив, тусламж нь хүлээн авсан өрхийн хувьд хэрэглээ болон бүртгэгдэнэ. Мөн татвар, хураамжууд нь зайлшгүй хийгдэх төлбөрүүд болохоос биш бараа, үйлчилгээний

хэрэглээнд хамааралгүй тул тэдгээрийг хасна. Ийм байдлаар хамааралтай байх шалгуурыг хангана. Нийтлэг хэрэглээ байх, хамааралтай байх гэсэн эдгээр шалгуур давхар хангагдсанаар хэрэглээ нь өрхийн өнөөгийн, өдөр тутмын аж байдлыг үнэн зөв тусгаж чадна.

Эрүүл мэндийн зардлыг ядуурлын тооцоонд оруулах эсэх нь маргаан дагуулж ирсэн сэдэв бөгөөд тухайн улсын нөхцөл байдал, онцлогоос хамаардаг. Эрүүл мэндийн зардлыг өрхийн аж байдлыг тэр болгон ахиулаад байдаггүй 'харамсалтай хэрэгцээ' гэж үзэж болох юм. Гэвч Манчини ба Векчи (2022) нар эрүүл мэндийн зардлыг хасах нь эрүүл мэндийн үйлчилгээний өрхийн аж байдлыг сайжруулах боломж, чадавхийг орхигдуулах эрсдэлтэйг онцолсон байдаг. Нөгөө талаас эрүүл мэндийн зардлыг орууллаа гэхэд зайлшгүй шаардлагаар эрүүл мэнддээ өндөр зардал гаргахад хүрсэн

өрхүүдийн хувьд амьжиргааны түвшин хэт өндөр мэт харагдана. Эрүүл мэндийн зардлыг хэрэглээнд оруулна гэвэл түүнийг нийт зардалтай нь харьцуулж хэр мэдрэмжтэй байгаагаас шалтгаалан тооцоонд оруулах эсэхээ шийдвэрлэж болно. Өөрөөр хэлбэл, өрхийн зардал нэмэгдэх тусам эрүүл мэндийн зардал нэмэгдэж байвал өндөр мэдрэмж (жишээ нь, 1-ээс их)-тэй гэж үзнэ. Энэ хамаарал нь өрхийн аж байдлыг сайжруулах тул тооцоонд оруулах нь зүйтэй. Монгол Улсын эрүүл мэндийн зардлын мэдрэмж 2022 онд 1.05 гарсан тул хүнсний бус хэрэглээнд оруулах нь үндэслэлтэй юм.

Манчини ба Векчи (2022) нарын зөвлөмжийн дагуу ӨНЭЗС-нд бүртгэгдсэн нийт бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс 65 нэр төрлийг хүнсний бус хэрэглээнээс хасаж, 239 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ үлдсэн. Хүснэгт 1.1-д хассан зүйлс, шалтгааныг тайлбарлав.

Хүснэгт 1.1 Хэрэглээний агрегатаас хассан хүнсний бус зарлага

Хүнсний бус зүйл	2022 оны ӨНЭЗС-нд цуглуулсан нэр төрлийн тоо	Тооцоололд ашигласан хэрэглээний нэр төрлийн тоо	Хасах шалтгаан, үндэслэл
Хувцас, гутал	45	45	
Өрхийн тоног төхөөрөмж/үйлчилгээ	69	45	Удаан эдэлгээтэй бараа; томоохон дүнтэй зарцуулалт; бизнест шаардлагатай орц
Эрүүл мэнд	10	10	
Тээвэр	26	21	Удаан эдэлгээтэй бараа
Харилцаа холбоо	22	14	Удаан эдэлгээтэй бараа
Амралт	30	27	Удаан эдэлгээтэй бараа
Боловсрол	8	8	
Ресторан, зочид буудал	2	2	
Хувийн арчилгаа	27	24	Томоохон дүнтэй зарцуулалт
Даатгал болон бусад үйлчилгээ	11	9	Өдөр тутмын хэрэглээ биш (санхүүгийн үйлчилгээ)
Байрны засвар	13	5	Удаан эдэлгээтэй бараа; томоохон дүнтэй зарцуулалт (байрны засвар)
Орон сууц, нийтийн аж ахуй	18	18	
Согтууруулах ундаа, тамхи	11	11	
Баяр, тэмдэглэлт үйл явдал	5	0	Томоохон дүнтэй зарцуулалт; бусад айлд өгсөн бэлэг; хоол хүнс
Татварууд	4	0	Хэрэглээ биш
Хандив, шилжүүлэг	3	0	Хэрэглээ биш; давхар тооцоолол
Бүгд	304	239	

Хүнсний бус хэрэглээг бүхлээр нь хэмжихэд анхаарах өөр нэг чухал зүйл бол татаастай бараа, үйлчилгээг тооцох явдал юм. Татаас, хөнгөлөлттэй бараа, үйлчилгээг тооцоонд хамруулах нь маш чухал билээ. Учир нь нөөцийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлснээр өрхийн аж байдал шууд сайжирна. Харин эдгээр хөнгөлөлтийг тооцоо судалгаанаас хасах тохиолдолд амьжиргааны түвшинг буруу тооцоолох, ядуурлын чиг хандлагыг буруу илэрхийлэх, өрхийн эрэмбийг буруу тогтоох зэрэг хүндрэл үүсч, эцсийн дүндээ ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийн үр дүн гажуудахад хүрнэ.

Хэрэглээний бүх бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлийн үнээр үнэлнэ гэсэн зарчмын дагуу хэрэглээнд багтсан татаастай бараа, үйлчилгээ болох цахилгаан, нүүрс, ус, халаалт зэргийг ч мөн зах зээлийн үнээр үнэлнэ. Цахилгааны хэрэглээг тооцоход тулгарч буй сорилтуудыг дурдвал нэгд, Засгийн газар Ковид-19 цар тахлын үед цахилгааныг үнэ төлбөргүй нийлүүлсэн айл өрхүүд 2022 оны эхний хагасын судалгаанд хамрагдсан; хоёрт, Улаанбаатар хотын гэр хорооллын айл, өрхүүдэд шөнийн цагаар цахилгааныг үнэ төлбөргүй нийлүүлж байгаа явдал юм. 2022 оны эхний хагаст судалгаанд хамрагдсан өрхүүдийн цахилгааны хэрэглээг тооцоходоо Хэнтшэл болон Ланжоу (Hentschel & Lanjouw 2000) нарын загварт суурилсан симуляц аргыг ашиглав. Тооцоо хийхдээ 2022 оны хоёр дахь хагаст судалгаанд хамрагдсан өрхүүдийн цахилгааны хэрэглээг ашиглан оны эхний хагасын хувьд симуляци хийв. Шөнийн цахилгааны хэрэглээний хөнгөлөлтийг тооцохын тулд хөнгөлөлтөд хамрагдсан болон хамрагдаагүй³ өрхүүдийн цахилгааны тоолуурын зөрүүг ашиглав.

Ковид-19 цар тахлын үед татаастай байсан бусад хэд хэдэн хэрэглээг үнэн зөв тооцоолохын тулд тохируулга хийх шаардлагатай болсон. Шахмал түлшний татаас 2021, 2022 онд харилцан адилгүй байсан ба 2022 оны ӨНЭЗС-гаар хэрэглээний

хэмжээг тогтоосноор татаасыг тодорхойлох боломжтой болсон. Өөрөөр хэлбэл, цуглуулагдсан шахмал түлшний хэрэглээний хэмжээг зах зээлийн үнээр (татаасгүй үнэ) үнэлж, нийт хэрэглээ болон татаасаас бий болох ашиг тусыг зөв тооцох боломжтой болсон юм. 2021 онд үнэгүй нийлүүлсэн ус, хогны үйлчилгээний хувьд жилийн хэрэглээг тооцоходоо нэг сарын хэрэглээ (нэхэн санаж мэдээлсэн)-нд суурилсан бол 2022 оны нэгдүгээр сард хог, усны мэдээлэл өгөөгүй өрхүүдийн хэрэглээг пробит загвараар үнэлэв. Үүнтэй адилаар дулааны хэрэглээг загвараар үнэлсэн ба ингэхдээ дулаан нийлүүлдэг, нийлүүлдэггүй саруудын тохируулгыг хийв.

1.3 Удаан эдэлгээтэй барааны хэрэглээ

Гэр ахуйн цахилгаан бараа, компьютер, машин зэрэг удаан эдэлгээтэй барааны үйлчилгээг айл өрхүүд нэг биш жилийн хугацаанд хүртэж байдаг тул тэдгээрийг худалдан авсан үнийг хэрэглээнд шууд нэмж тусгах боломжгүй юм. Үүний оронд тухайн бүтээгдэхүүний бий болгох үйлчилгээний үнийг эсвэл ийм активын судлагдаж буй хугацаанд бий болгох “хэрэглээний урсгал”-ыг л хэрэглээнд хамруулна.

Удаан эдэлгээтэй барааны эзэмшлийн өгөгдөл

ӨНЭЗС-гаар 2022 онд өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээтэй барааны тоо хэмжээ, анх худалдаж авсанаас хойш хэрэглэж буй хугацаа, худалдан авсан үнэ болон хэрэв өрх тухайн барааг зарлаа гэхэд хэдэн төгрөгөөр зарах боломжтой эсэх мэдээллийг цуглуулсан. Хэрэв өрхөд нэг төрлийн удаан эдэлгээтэй бараа хэд хэд байгаа бол ӨНЭЗС-гаар эзэмшиж буй барааны тоо, эзэмшиж буй дундаж хугацаа, анх худалдаж авсан үнийн дундаж болон одоогийн үнийн дундаж утгуудын талаарх мэдээллийг өрхөөс авна.

3 Шөнийн цахилгааны хэрэглээний хөнгөлөлтөд хамрагдсан өрхүүдийн хувьд 2 тарифт тоолуур суурилуулдаг.

Тооцох арга зүй

Удаан эдэлгээтэй барааг хэрэглэснээр өрхийн хүртэх хэрэглээний урсгалыг тооцоолохын тулд Манчини болон Векчи (2022) нарын санал болгосон хэрэглэгчийн зардлын аргыг ашиглав. ӨНЭЗС-нд 45 нэр төрлийн удаан эдэлгээтэй барааны хэрэглээний урсгалыг тооцохдоо 2 бүрэлдэхүүн хэсгийн нийлбэрээр тодорхойлно: 1) удаан эдэлгээтэй барааг жилийн турш хэрэглэснээс үүдэлтэй алдагдсан боломжийн өртөг (өөрөөр хэлбэл, өрхүүд удаан эдэлгээтэй барааны оронд хөрөнгө оруулалт хийснээр олох байсан орлого буюу хөрөнгө оруулалтаас олж болох байсан ашиг) болон 2) судалгааны хамрах хугацаан дахь барааны үнэ цэнийн бууралт (энэ нь өрхийн хувьд мөн алдсан мөнгийг илэрхийлнэ). 2022 оны ӨНЭЗС-

гаар цуглуулсан мэдээлэлд үндэслэн i нэр төрлийн удаан эдэлгээт бараа бүрийн хувьд элэгдлийн түвшин δ -г тооцоолох боломжтой.

Тэгшитгэл

$$(4) \quad \delta_i = 1 - \left(\frac{p_t}{p_{t-T}} \right)^{\frac{1}{T}}$$

Энд T нь удаан эдэлгээт барааны хэрэглэсэн хугацаа, жилээр; p_t нь барааны одоогийн зах зээлийн үнэ, p_{t-T} нь барааг худалдаж авах үеийн үнэ. Тухайн бараа бүрийн хувьд ажиглалтуудын дундаж утгыг авч зөвхөн нэг элэгдлийн түвшин тооцно. Бараа бүрийн элэгдлийн түвшин, судалгааны үеийн (r_t) бодит хүү⁴-г ашиглан h өрх бүрийн удаан эдэлгээтэй барааны урсгалыг тодорхойлно.

Тэгшитгэл

$$(5) \quad \text{Удаан эдэлгээтэй барааны урсгал}_h = \sum_{i=1}^n \text{Тоо хэмжээ}_{ih} \times (p_{ih} \times (r_{ih} + \delta_i))$$

1.4. Орон сууцны хэрэглээ

Удаан эдэлгээтэй барааны нэгэн адил орон сууц нь судалгааны хамрах хугацаанаас илүү хугацаагаар хэрэглэгддэг тул орон сууцны худалдан авалтын үнийг шууд хэрэглээнд оруулахгүй. Гэхдээ удаан эдэлгээтэй бараанаас ялгаатай нь орон сууцны үнэ цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нэмэгдэж байдаг. Судалгаанаас харахад түрээсийн зах зээл нь орон сууцны бий болгох үйлчилгээний урсгалыг баримжаалах сайн үзүүлэлт болж чаддаг. Гэсэн хэдий ч Монгол Улсын хувьд түрээс төлж суудаг өрх харьцангуй цөөн тул өөрийн эзэмшлийн сууцандаа амьдардаг өрхүүдийн хувьд орон сууцны бий болгох үйлчилгээний урсгалыг өөр аргаар судлах шаардлагатай. Ялангуяа гэрийн хувьд ихээхэн онцлог шинжтэй тул онцгойлон авч үзэх шаардлагатай байдаг.

Орон сууцны өгөгдөл

ӨНЭЗС-гаар 2022 онд орон сууцны талаар (өрх эзэмшдэг, түрээсэлдэг, үнэгүй суудаг, түрээсэлдэг бол хэдэн төгрөгөөр гэх мэт) дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулсан. Мөн оршин суугаа сууцны нийт талбай, хана, тааз, шалны үндсэн материал болон урсгал зардал болох цахилгаан, ус, халаалтын зардлыг цуглуулсан, харин гэрийн тухайд ханын тоо, дээвэр, туурга нь давхар уу гэсэн нэмэлт мэдээллийг цуглуулсан байна.

Тооцох арга зүй

Түрээсийн зах зээл сайтар хөгжсөн, айл өрхүүд бүгд байр түрээсэлж буй нөхцөлд бодит түрээсийг орон сууцны хэрэглээнд шууд ашиглаж болно. Гэвч зарим өрх нь түрээсэлдэг, зарим нь өөрийн сууцанд

4 Бодит хүүгийн түвшинг Монголбанкны тогтоосноор авав. Бодит хүүгийн дундаж түвшин 2022 онд 3.6% байсан.

амьдардаг, зарим нь үнэгүй суудаг холимог зах зээлтэй нөхцөлд өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийг тооцохдоо хедоник регрессийн загварыг (hedonic pricing model) ашиглана. Тус загвараар орон сууцны байршил, үндсэн материалууд, урсгал зардлуудын шинж чанараас хамааруулан түрээсийн үнийг үнэлнэ. Ингэснээр өөрийн эзэмшлийн сууцны түрээсийг таамаглах боломжтой болно. Энэхүү аргыг ашиглахын тулд түүвэр олонлогийг хангалттай олон түрээслэгчдээс бүрдүүлэх хэрэгтэй.


Түрээсийн мэдээлэл хомс тохиолдолд судалгаагаар өрхөөс сууцаа түрээслэхээр болсон тохиолдолд сард хэдэн төгрөгөөр түрээслэх байсныг асууж “Судалгаанд хамрагдагчийн тайлагнасан” үнэлгээгээр тооцно. Гэвч ийнхүү өөрөө тайлагнасан түрээсийн үнэн зөв байдал нь хариулагчийн түрээсийн зах зээлийн талаарх мэдлэгээс

ихээхэн хамаарах билээ. Түрээсийн зах зээл цомхон нөхцөлд өөрөө тайлагнасан түрээсийн үнэ найдваргүй байж болно.

ӨНЭЗС-гаар 2022 онд нийт өрхийн 3 хүрэхгүй хувь нь түрээс төлж байгаа нь түрээсийн зах зээл маш бага байгааг харуулж байна (Зураг 1.3). Монгол гэрийн хувьд түрээсийн мэдээлэл бараг байхгүй бөгөөд нийт өрхийн гуравны нэг нь гэрт амьдарч байна. Тэр ч байтугай орон сууцны байранд амьдарч буй өрхүүдийн 7 хүрэхгүй хувь нь түрээс төлдөг хэмээн хариулжээ. Ийм хязгаарлалтыг харгалзан өөрөө тайлагнасан түрээсээр дамжуулан түрээсийн төлбөрийг үнэлэх шаардлагатай болж байна. Өрхийн дөрөвний нэг орчим хувь нь түрээсийн хэмжээг өөрсдөө тайлагнасан байна. Энэ мэдээллийг зах зээлийн түрээсийн үнэтэй зэрэгцүүлэн сууцандаа өөрсдөө суудаг өрхүүдийн хийсвэр түрээсийг тооцно.

Зураг 1.3

ӨНЭЗС-ны 2022 оны мэдээлэлд бодит түрээс, өөрийн тайлагнасан түрээс, сууцны үнэлгээ, орон сууцны төрлөөр



Өөрийн тайлагнасан түрээсийн төлбөрийн мэдээлэл сууцны төрлөөс хамааран харилцан адилгүй байна. Түрээсийн зах зээл бараг байхгүй монгол гэрийн хувьд өрхүүдийн тайлагнасан түрээсийн үнэ тодорхой хандлагагүй, тархалт нь тодорхой бус байгаа нь өгөгдөл найдваргүйг харуулж

байна. Харин гэр бус орон сууцны хувьд өөрийн тайлагнасан түрээсийн төлбөр нь зах зээлийн бодит түрээстэй ойролцоо байгаа бөгөөд хэмжээ, чанарт тохируулга хийсний дараа бараг ялгаагүй шахуу байна. Иймээс орон сууц, тусдаа байшин зэрэг гэрээс бусад сууцны хувьд өөрөө тайлагнасан түрээсийг

ашиглаж болохоор байна. Харин монгол гэрийн хувьд өөр арга ашиглах шаардлагатай болж байна.

ӨНЭЭС-гаар үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг мөн цуглуулдаг бөгөөд түүнийг монгол гэрийн түрээсийг тооцоолоход ашиглаж болох юм. Мэдээллийн олдоцын хувьд түрээсийг бодвол сууцны зах зээлийн үнэлгээг илүү сайн тайлагнадаг ажээ. Ялангуяа монгол гэрийн хувьд түрээс гэхээсээ илүүтэй зах зээлийн үнийн мэдээлэл олдоц сайтай байна (Зураг 1.3). Энэхүү өгөгдөл нь нормал тархалттай байгаа нь гэрийн түрээсийн үнийг үнэн зөвөөр үнэлэх боломжтойг харуулсан.


Иймд гэр болон гэрээс бусад сууцны (орон сууц, сууцны тусдаа байшин гэх мэт) түрээсийн үнийг үнэлэхдээ 2 тусдаа аргыг ашигласан (Зураг 1.4). Үүнд:

- **Гэрээс бусад сууц** – Монгол гэрбиш сууцны хэрэглээний урсгалыг бодит түрээс болон өөрийн тайлагнасан түрээсийн үнийг ашиглан хедоник регрессийн загвараар тооцов. Тус загвар дахь хэрэглээний урсгал нь орон сууцны шинж чанар, байршил, үйлчилгээний хүртээмж зэрэгт суурилсан болно. Түүврийг сургалтын болон туршилтын (training and testing groups) гэсэн 2 бүлэгт хуваасан бөгөөд туршилтын түүврийн мэдээллийг ашиглан хувьсагчдыг сэлгэж R^2 -ыг хамгийн их байх үеийг тогтооно. Дараа нь Дуаны хувиргагч (Duan's smearing estimator)-ийг ашиглан түрээсийг үнэлэх ба тус үнэлгээг өөрийн эзэмшлийн сууцандаа амьдарч буй бүх өрхүүдэд тархаан тооцно. Сууцны төрөл, байршил, талбай, ус, цахилгаан, дулаан хангамж зэрэг хувьсагч бүхий загварыг үнэлэхэд R^2 0.6446 буюу харьцангуй өндөр гарсан.

- **Гэр сууц** – Гэр сууцны хувьд удаан эдэлгээтэй барааг тодорхойлоход ашигласан Манчини болон Векчи нарын түрээсийн үнийн аргыг ашиглана. Хийсвэр түрээсийн үнийг тухайн өрх гэртээ өөрсдөө амьдарснаас үүдсэн алдагдсан боломжийн өртгөөр тооцно. Алдагдсан боломжийн өртгийг капиталжуулалтын түвшин (түрээсийн үнийг сууцны зах зээлийн үнэд харьцуулсан харьцаа) ашиглан тооцож өөрийн тайлагнасан сууцны зах зээлийн үнэлгээнд ашиглана. Монгол гэрүүдийн хувьд өөрийн тайлагнасан гэрийн зах зээлийн үнэлгээ (гэрт амьдарч буй өрхийн 85 хувьд нь боломжтой)-г ашиглана. Харин хоосон утга эсвэл хэт онцгой утгын хувьд орлуулалт хийхэд хедоник регрессийн загварыг ашиглана. Аймгийн түвшний капиталжуулалтын түвшинг тооцохдоо гэрээс бусад сууцны түрээсийн болон сууцны үнийг ашигласан болно. Эдгээр голч харьцаа 0.07-0.13-ын хооронд хэлбэлзэж байв. Дараа нь эдгээр хувийг сууцны үнэд хэрэглэж, гэрийн хийсвэр түрээсийг тооцно.

Зураг 1.4

Сууцны төрөл, өгөгдлийн боломжид суурилан ӨНЭЗС-наас түрээсийн төлбөрийг тооцсон аргачлал





1.5 Нэгтгэсэн хэрэглээ

Хэрэглээ нь хүнс, хүнсний бус зардал, удаан эдэлгээтэй барааны бий болгох хэрэглээний урсгал, түрээсийн үнэлгээгэсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй. Хүнсний бус (удаан эдэлгээтэй бус барааны) зардал хамгийн их буюу 42 хувийг эзэлж байгаа бол удаан эдэлгээтэй бараа 13 хувь, орон сууцны зардал 15 хувийг эзэлж байна (Зураг 1.5а). Хүнсний хэрэглээ нийт хэрэглээний дөнгөж 30 хувийг эзэлж байгаа нь бусад дундаж орлоготой орнуудтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм.

Хүнсний хэрэглээний эзлэх хувь алслагдсан бүс нутагт өндөр байгаа ч 40 хувиас доогуур байна. Өрхийн хамгийн ядуу 10 хувьд хүнсний хэрэглээ нийт зардлын 44 хувийг (Зураг 1.5б) бүрдүүлж байгаа нь бусад улс оронтой харьцуулахад Монгол Улсын хүнсний бус хэрэгцээ харьцангуй илүү байгааг харуулна. Тухайлбал, дундаас дээш орлоготой Индонезид хамгийн ядуу 20 хувь нь хэрэглээнийхээ 60 орчим хувийг хүнсний бүтээгдэхүүнд зориулдаг бол Монголд тус үзүүлэлт ердөө 42 хувьтай байна.

Зураг 1.5 Өрхийн сарын дундаж хэрэглээний бүтэц



2. ХЭРЭГЛЭЭНИЙ ТОХИРУУЛГА



Нэгтгэсэн хэрэглээнээс аж байдлын үзүүлэлтийг гаргаж авахын тулд хоёр үндсэн тохируулгыг хийнэ. Нэгд, амьжиргааны өртгийн ялгавартай байдалд хийх тохируулга нь судалгааны хамрах хугацааны инфляци болон Монголын бүс нутгийн үнийн ялгаатай байдалтай холбоотой. Эдгээр тохируулга нь

өрхүүдийн худалдан авах чадварыг улирлаар болон байршлаар харьцуулах боломж олгоно. Хоёрт, өрхийн ам бүлийн тоо, бүтцэд тохируулга хийж аж байдлын үзүүлэлтийг үнэлнэ. Энэ нь өрхийн ам бүлийн тоо, бүтэц бүрэлдэхүүнээс шалтгаалсан өрхийн хэрэглээний ялгаатай байдлыг арилган харьцуулах боломж олгоно. Эдгээр тохируулга

нь өрхүүдийн аж байдлыг бодитой харьцуулах боломжийг олгох билээ.

2.1 Өрхийн ам бүлийн тоо, бүтцийн тохируулга хийх нь

Өрхийн ам бүлийн тоо, бүрэлдэхүүнд тохируулга хийснээр хэрэглээ нь хувь хүний аж байдлын бодитой илрэл болж чадна. Өрхийн нийт хэрэглээг гишүүдийнх нь тоонд (нэг хүнд ногдох тохируулга) шууд хувааж олон улсын ядуурлын шугамтай зэрэгцүүлж болох ч энэ нь хэд хэдэн сул талтай. Нас, хүйс болон хүн ам зүйн бусад шинж чанараас хамааран өрхийн гишүүдийн хэрэгцээ ялгаатай байх тул нэг хүнд ногдох тохируулга нь аж байдлын түвшинг тэр болгон бодитой илэрхийлэхгүй. Жишээ нь, нэг хүнд ногдох хувилбараар олон хүүхэдтэй айл өрхийн аж байдал нь насанд хүрсэн хүмүүс бүхий айл өрхийн аж байдалтай адилхан гарч болно. Гэтэл хүүхдийн хэрэглээ насанд хүрсэн хүнийг бодвол доогуур байна.

Эдийн засгийн чадамжийг хэмжихэд хүндрэл үүсдэг. Орон сууц, сууц ашиглалтын зардлууд, удаан эдэлгээтэй бараа зэрэг хүнсний бус олон бүтээгдэхүүн нь нийтийн буюу өрхийн гишүүд хамтран хэрэглэж болох бараа байдаг. Харин хүнсний хувьд хамтын хэрэглээ гэх зүйл үндсэндээ байхгүй. Манай улс шиг хүнсний бус хэрэглээ өндөртэй улсын хувьд эдийн засгийн чадамжийг зайлшгүй авч үзэх шаардлагатай (Jolliffe & Tetteh Baah, 2022). Жишсэн насанд хүрсэн хүнээр тохируулга хийж хувь хүний болон нийтийн хэрэглээний аль алиныг харгалзан үзэх замаар дээрх асуудлыг шийдвэрлэх ба ингэснээр өрхийн бүтэц, ам бүлийн ялгааг орхигдуулалгүйгээр аж байдлын онцлогийг илүү гаргах боломжтой болдог.

Жишсэн насанд хүрсэн хүнээр тохируулга хийнэ гэдэг нь өрхийн гишүүн бүрийг насанд хүрсэн эрэгтэй хүн рүү шилжүүлэн жишиж байна гэсэн үг. Ийнхүү жиших олон арга байдаг ч аль нь “хамгийн сайн” талаар зөвшилцөл байдаггүй бөгөөд сонголт нь тухайн улсын нөхцөл байдал, өрхийн хэрэглээний бүтцээс ихээхэн хамаарна. Ялангуяа хамтын

хэрэглээтэй орон сууц, сууц ашиглалтын зардлууд зэрэг хүнсний бус хэрэглээ өндөртэй нөхцөлд өрхийн гишүүдийн эдийн засгийн чадамжийг харгалзан үзэх нь чухал асуудал юм. Монгол Улсад Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас боловсруулсан OECD-I тэнцвэржүүлэх хэмжээсийг (Тэгшитгэл 6) ашигласан. Энэ нь өрхийн эхний насанд хүрсэн (А) гишүүнд 1.0, дараагийн насанд хүрсэн гишүүн бүрд (А) 0.7, хүүхэд (К) бүрд 0.5 гэсэн жин өгдөг. OECD-I тэнцвэржүүлэх хэмжээс нь өрхийн ам бүлийн тоо, бүтэц болон эдийн засгийн чадамжийн ялгаатай байдалд тохируулга хийнэ.

Тэгшитгэл

$$(6) \quad ES_{OECD-I} = 0.3 + 0.7A + 0.5K$$

2.2 Амьжиргааны өртгийн ялгавартай байдалд тохируулга хийх нь

Цаг хугацаа (судалгааны хугацаанд) болон орон зай (Монгол Улсын газарзүйн бүс нутгууд) дахь амьжиргааны өртгийн зөрүүнд тохиргоо хийхийн тулд ӨНЭЗС-ны 2022 оны мэдээллээс үнийн дефляторыг тооцов. Үнийн хэлбэлзлийг тохируулахад хэрэглээний үнийн индексийг (ХҮИ) ашиглаагүй болно. Монголын хувьд ХҮИ-ийг гол төлөв төв суурин газрын зах зээлийн мэдээлэлд тулгуурлан тооцдог тул ядуу өрх олноор амьдарч буй хөдөө орон нутгийн үнийн зөрүүг тайлбарлахад тохиромжгүй юм. Мөн ХҮИ нь дундаж хүн амын хэрэглээний сагсыг илэрхийлдэг тул ихэнх тохиолдолд энэ нь ядуу өрхүүдийн хэрэглээний сагснаас ялгаатай байдаг. ӨНЭЗС-наас өрхийн үнийн мэдээллийг ашигласнаар ядуу өрхийн амьжиргааг илүү сайн илэрхийлэх боломжтой. ӨНЭЗС-наас айл өрхүүдийн хэрэглэж буй зүйлсийн төрөл, чанарын зөрүү нь тод томруун харагдах тул ядуу өрхүүдийн амьжиргааг илүү сайн илтгэнэ. Тиймээс ядуурлыг хэмжихээр бүрдүүлсэн сагсны бүтэц ба үнийн индекс нь ХҮИ-ээс ялгаатай байхаар байна.

Монголын хувьд ядуу хүн амын дунд хүртэл хүнсний бус хэрэглээ нь хэрэглээний ихэнх хувийг бүрдүүлэх тул үнийн индексэд хүнсний бус барааг оруулах нь чухал юм. Гэвч ӨНЭЗС-ны 2022 оны мэдээллээр хүнсний бус бараа, бүтээгдэхүүний хувьд үнийг нь биш зөвхөн зарлагын мэдээллийг цуглуулсан. Иймд үнийн индексийн тооцоонд ӨНЭЗС-ны 2022 оны мэдээлэл болон ҮСХ-ны 2022 оны аймгийн түвшний сарын ХҮИ-ийн судалгааны хүнсний бус бараа, бүтээгдэхүүний үнийн өгөгдлийг мөн ашиглав. Үнийн тохируулга хийхдээ дараах дөрвөн үе шатыг хамарна (Манчини ба Векчи, 2022; Дитон ба Зайди, 2002). Үүнд;

- 1. Жишиг бүлгийг сонгох нь** – Үнийн индекс нь ядууст хамааралтай байхын тулд жишсэн насанд хүрсэн хүнээр тохируулсан хэрэглээний⁵ 20-иос 50 дахь перцентильд багтах өрхүүдийг сонгож жишиг бүлгийг тодорхойлно.
- 2. Хэрэглээний сагсыг тодорхойлох нь** – Жишиг бүлгийг ашиглан хүнсний болон хүнсний бус барааг дундаж зардлын жингээр нь буурах эрэмбээр жагсааж, хамгийн доогуур эрэмбэлэгдэж, нийлбэр дүн нь нийт хэрэглээний 10 хувиас бага хувийг эзэлж буй бараануудыг хасна. Ингэснээр 64 төрлийн бараанаас (27 нь хүнсний бараа, 37 нь хүнсний бус) бүрдсэн хэрэглээний сагс бий болж байна.
- 3. Индекс тооцох түвшинг тодорхойлох нь** – Албан ёсны статистикт ХҮИ-ийг сар бүр аймгаар гаргадаг. Үнийн индексийг тооцохдоо аймаг-сар эсвэл аймаг-улирал гэсэн 2 хувилбарыг авч үзсэн болно. Ингээд сагсан дахь барааны ажиглалтын тоог харгалзан үзвэл аймаг-улирал хувилбарыг сонгох нь тохиромжтой байв. Амендола (Amendola et al., 2023) нарын зөвлөмжийн дагуу тохируулгыг аймгууд доторх улирлын үнийн ялгааны хувьд, цаашлаад аймаг хоорондын үнийн ялгааны хувьд гүйцэтгэсэн болно.

4. Үнийн индексийг тооцох – Пааше индексийг Дитон болон Зайди (2002) нарын томъёог ашиглан тооцоолно (Тэгшитгэл 7).

Тэгшитгэл

$$(7) \quad p_p^h = \left(\sum w_k^h \frac{p_k^o}{p_k^h} \right)^{-1}$$

Энд w_k^h аймаг-улирал бүр дэх h өрхийн k нэр төрлийн дундаж үнийн эзлэх хувь; w_k^o - улсын түвшин дэх k нэр төрлийн хэрэглээний эзлэх хувь; p_k^h аймаг-улирал бүр дэх h өрхийн k нэр төрлийн худалдан авсан үнийн голч; p_k^o улсын түвшин дэх k нэр төрлийг худалдан авсан үнийн голч;

Үнийн харьцааг бүрдүүлэхдээ ХҮИ-ийн судалгаанаас хүнсний болон хүнсний бус бүлгүүдийн бараа бүрийн голч үнүүдийг ашиглав. Эдгээр үнийн харьцаанд (нэгдүгээр алхамд сонгосон жишиг бүлэгт суурилан тооцсон улсын болон аймгийн түвшний улирлын үнийн хувийн жингийн хамтаар) үндэслэн үнийн индексүүдийг тооцсон болно.

⁵ Перцентилийн мужийг өөрчилснөөр эсвэл жишсэн насанд хүрэгчид ногдох хэрэглээг ашигласнаар хэрэглээний сагсны бүтэц эсвэл жинд мэдэгдэхүйц өөрчлөлт орохооргүй байна.

3. ЯДУУРЛЫН ШУГАМЫГ ШИНЭЧЛЭХ НЬ



Хэрэглээг бүрдүүлсний дараа өрхийг ядуу биш гэж үзэх хэрэглээний хамгийн бага түвшин буюу ядуурлын шугамыг тодорхойлох шаардлагатай болдог. Монгол Улсын хувьд абсолют ядуурлын шугамыг ашигладаг. Энэ нь хүний үндсэн хэрэгцээг хангахад шаардлагатай наад захын хэрэглээний хамгийн бага зардал юм. Уг ядуурлын шугамыг тодорхой онд шинэчлэн тооцдог ба ядуурлын шугамыг дахин шинэчлэх хүртэл дараа дараагийн жилүүдэд тухайн ядуурлын шугамыг хэрэглээний үнийн өөрчлөлтөөр завсарлан тооцдог. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр амьжиргааны түвшин өөрчлөгдөх тул улс орнууд ядуурлын шугамыг 10 жилд нэг удаа шинэчилдэг. Монгол Улс өмнө нь 2010 оны ядуурлын шугамыг суурь болгон авч 2022 он хүртэл хэрэглээний үнийн өөрчлөлтөөр засварлан тооцож ирсэн. Харин 2022 оны мэдээлэлд үндэслэн ядуурлын шугамыг шинэчлэн, суурь оныг өөрчилж байна. Ядуурлын шугамын суурь оныг өөрчилсөн тохиолдолд хуучин болон шинэ ядуурлын шугамд суурилсан ядуурлын үзүүлэлтүүдийг шууд харьцуулах боломжгүй болох тул шинэ ядуурлын шугам шинэ хугацааны цувааг үүсгэдэг.

Монгол Улс ядуурлын шугамаа тооцохдоо үндсэн хэрэгцээний зардлын аргыг ашигладаг. Энэ арга нь наад захын хамгийн бага хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний сагсыг тодорхойлж, түүний өртөг буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зардлын дүнг тооцно. Хэрэглээний сагс нь эрүүл, идэвхтэй амьдрахад шаардлагатай илчлэг, хоол тэжээлийн хэрэглээ болон нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай бараа, үйлчилгээгээр хангагдах суурь хоёр чадамжийг хамрахыг зорьдог. Өөрөөр хэлбэл, үндсэн хэрэгцээний зардлын аргаар тооцогдсон ядуурлын шугам нь хүнс болон хүнсний бус гэсэн хоёр бүрэлдэхүүнтэй байна.

Тооцох арга зүй

Үндсэн хэрэгцээний зардлын аргыг ашиглан ядуурлын шугамыг тооцох үйл явц нь дараах 5 үе шатаас бүрдэнэ. Үүнд;

1. **Жишиг бүлгийг тодорхойлох** – Тохиромжтой хэрэглээний сагсыг тодорхойлохын тулд эхлээд өрхийн жишиг бүлгийг тодорхойлдог. Ядуу хүмүүсийн хэрэглээний сагсыг тодорхойлох зорилготой ч ядуурлын шугам хэд гэдэг нь тодорхойгүй тул ядуу хүмүүс багтах боломжтой жишиг бүлгийг эхлээд тодорхойлно. Үүний тулд ядуурлын түвшний статистик тоон мэдээллийг үндэслэн жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох хэрэглээг багаас их рүү эрэмбэлээд хоёрдугаар квантил бүлэг буюу доогуур хэрэглээтэй 20-40 хувийн бүлгийг эхний жишиг бүлгээр тодорхойлно. Үүний дараа 2-5 хүртэлх алхмуудыг дараалуулан гүйцэтгэж 5-р алхмаар ядуурлын шугамыг тодорхойлно. Ингэж тодорхойлсон ядуурлын шугам нь дараагийн жишиг бүлгийн төв цэг болж, хоёр дахь жишиг бүлгийг тодорхойлон дахин 2-5 хүртэлх алхмуудыг гүйцэтгэн хоёр дахь ядуурлын шугамыг тодорхойлно. Энэ давталтыг шинээр тодорхойлогдох ядуурлын шугам бүрээр гарч ирсэн ядуурлын түвшний зөрүү маш бага байх түвшинд (<0.01 нэгж хувь) очих хүртэл давтаж, хамгийн сүүлд тодорхойлогдсон бүлгээр жишиг бүлгийг сонгоно.
2. **Хүнсний сагсыг бүрдүүлэх нь** – Хүнсний сагсыг жишиг бүлгийн хувьд хэрэглээний жин хамгийн өндөр, хүнсний нийт хэрэглээний 90 орчим хувийг багтаасан зүйлсээр бүрдүүлнэ. Монгол Улсын газарзүйн харилцан адилгүй онцлогийг харгалзан үзэж сагсыг Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төв, хөдөө нутгаар тус тусад нь бүрдүүлнэ. Ингэхдээ сагс бүрийн хувьд дээрх 90 хувийн шаардлагыг тавина.

Хавсралтын Хүснэгт 1-д үзүүлсэнчлэн эцсийн сагсанд 34 зүйл багтсан байна. Жишиг бүлгийг ашиглан насанд хүрсэн хүнд ногдох өдрийн дундаж хэмжээг зүйл тус бүрээр тооцно.

3. Хүнсний ядуурлын шугамыг тооцох нь – Хүнсний сагсны нийт илчлэгийн хэмжээг тооцно. Хүнсний сагсны нэр төрөл болгоноор нэгжийн үнийг тооцож, хэрэглэсэн хэмжээгээр үржүүлэн, нийлбэр дүнгээр нийт хүнсний сагсанд зарцуулсан зардлын дүнг олно. Эндээс хоногт эрүүл идэвхтэй амьдрахад шаардлагатай зохистой түвшний илчлэгийг нийт хүнсний сагсанд шаардлагатай зардлын дүнгээр үржүүлж, хэрэглээний сагсаар тодорхойлогдсон нийт илчлэгийн хэмжээнд хуваана. Ингэж тодорхойлогдсон мөнгөн дүн нь хүнсний ядуурлын шугам байна. Эрүүл идэвхтэй амьдрахад шаардлагатай хэрэгцээг хангах сагсны зардлыг тогтоохын тулд ЭМЯ-наас зөвлөсөн жишсэн насанд хүрсэн эрэгтэй хүнд хоногт шаардлагатай 2,400 калорийн илчлэгийн босго хэмжээг ашиглав. 2022 онд насанд хүрсэн хүний хүнсний ядуурлын шугам өдрийн 5,603 төгрөг, сарын хүнсний ядуурлын шугам нь 170,414 төгрөг болсон (Хүснэгт 1.2).

4. Хүнсний бус бүрэлдэхүүн хэсгийг тооцоолох нь – Хүнсний бус бүрэлдэхүүнийг тооцохдоо Раваллион (Ravallion, 1998)-ы засварласан аргачлалыг ашиглав. Ингэхдээ хүнсний ядуурлын шугамд ойрхон айл өрхүүд дээр төвлөрнө. Жишсэн насанд хүрсэн хүний хүнсний ядуурлын шугамын ойролцоо амьдарч байгаа буюу доогуур хэрэглээтэй 10-40 хувийнхны хүнсний бус бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулж буй дундаж зардлын дүнгээр тооцно. Раваллионы аргачлал нь анхнаасаа хоол хүнсний хэрэглээ өндөртэй улс орнуудад зориулагдсан билээ. Гэтэл ӨНЭЗС-наас харахад Монгол Улсын хувьд хүнсний бус жин нэлээн өндөр тул Раваллионы аргачлалыг засварласан хувилбараар ашигласан.

5. Ядуурлын ерөнхий шугамыг тооцоолох нь – Ядуурлын ерөнхий шугам нь хүнсний ядуурлын шугам болон хүнсний бус бүрэлдэхүүн хоёрын нийлбэр юм. 2022 онд жишсэн насанд хүрсэн хүнээр тооцсон ядуурлын ерөнхий шугам нь хоногийн 13,744 төгрөг, сарын хүнсний ядуурлын шугам 418,045 төгрөг байна (Хүснэгт 1.2).


Хүснэгт 1.2 2022 оны ядуурлын шугам, жишсэн насанд хүрсэн нэг хүнээр тооцсон төгрөг

	Өдрийн	Сарын
Хүнсний ядуурлын шугам	5,603	170,414
Хүнсний бус бүрэлдэхүүн хэсэг	8,141	247,631
Ядуурлын ерөнхий шугам	13,744	418,045

Ядуурлын шугамыг шинэчлэн тогтоохдоо улс орны орлогын түвшинг харгалзан үзэх нь зүйтэй юм. Үүнийг үнэлэх нэг арга нь шинэ ядуурлын шугамаа ижил орлоготой улс орнуудын ядуурлын шугамуудтай харьцуулж үзэх явдал юм. Жоллиффе нарын (Jolliffe et al., 2022) зураг 1.6-д өгөгдсөн судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын 2022 оны ядуурлын шугам нь дундаас дээш орлоготой улс орны 2017 оны Худалдан авах чадварын паритетээрхи 6.85 ам.долларын ядуурлын

шугамаас бага зэрэг дээгүүр байгааг харж болно. Энэ нь Монгол Улс дундаас дээш орлоготой улс орон гэсэн статустай нийцтэй байхаар байна. Улс орон хөгжихийн хэрээр ядуурлын стандарт нь эдийн засгийн хөгжил дэвшлээ даган хувьсдаг байх нь чухал. Түүнчлэн шинэ шугам нь 2022 оны үнээр илэрхийлж засварласан 2010 оны ядуурлын шугамаас дээгүүр байгаа нь сүүлийн 10 жилд амьжиргааны түвшин дээшилснийг илтгэнэ.

Зураг 1. 6 Монгол Улсын ядуурлын шугамыг олон улстай харьцуулсан байдал





БҮЛЭГ:

2



ЯДУУРАЛ 2022 ОНД

Энэ бүлэгт 2022 оны ядуурал, тэгш бус байдлыг харуулахыг зорилоо.

Хүн амын ядуурлын түвшин 2022 онд 27.1 хувь болж, ойролцоогоор нийт хүн амын 913.7 мянга нь ядуу амьдарч байна.


Үндэсний ядуурлын шугам 2022 оны байдлаар 418,045 төгрөг болсон бөгөөд жишсэн насанд хүрсэн нэг хүний сарын хэрэглээ энэ босго хэмжээнээс доогуур бол ядуу хүн гэж тооцогдсон. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нийт хүн амын 27.1 хувь нь амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах зайлшгүй шаардлагатай хүнс болон хүнсний бус зүйлсээ худалдан авах чадваргүй байна гэсэн үг юм. Ядуурлын гүнзгийрэлт буюу ядуу хүний дундаж хэрэглээ⁶ ядуурлын шугамаас 6.5 хувиар доогуур байна. Харин ядуу хүн амын

дундах хэрэглээний тархалтыг харуулдаг ядуурлын мэдрэмж⁷ 2.3 хувь байна.

Хөдөөгийн ядуурал 2022 онд хот суурин газрын⁸ ядуурлаас ихээхэн өндөр байгаа нь хот, хөдөөгийн ялгаа мэдэгдэхүйц их байгааг илтгэж байна. Хөдөөд ядуурлын түвшин 35.5 хувь болж, хотынхоос 12.5 нэгж хувиар өндөр байна (Зураг 2.1а). Мөн хөдөө амьдарч буй хүмүүс илүү ядуу амьдарч байгаагаас гадна ядуурлын гүнзгийрэлт болон мэдрэмж хот суурин газрынхтай харьцуулахад өндөр байгаа нь ядуу хүн амын дунд ядуурлын эрчимжилт болон хэрэглээний ялгаа илүү илэрч байгааг харуулж байна.

Зураг 2.1

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, улсын дундаж, хот, хөдөөгөөр, 2022



6 Ядуурлын гүнзгийрэлт нь ядуу бус хүн амыг ядуурлын шугамаас 0 хувийн зөрүүтэй гэж үзвэл хүн тус бүрийн хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлнэ. Энэ нь ядуурлын эрчимжилтийг илэрхийлэх бөгөөд ядуу хүмүүсийн хэрэглээ ядуурлын шугамаас хэр хол байгааг харуулна. Ядуурлын гүнзгийрэлт өндөр байх тусам ядуурал илүү ноцтой, гүнзгий байгааг илтгэнэ.

7 Ядуурлын мэдрэмж нь ядуу хүн амын дундах хэрэглээний тархалт буюу тэгш бус байдлыг илэрхийлдэг. Энэ хэмжүүр нь ядуурлын шугамаас нэлээдгүй доогуур түвшинд байгаа өрхүүдийн хувьд илүү ач холбогдолтой тооцоолол байдаг. Тухайн өрхийн хэрэглээ нэмэгдсэн ч хэмжээ нь ядуурлын шугамаас доогуур байвал ядуурлын хамрах хүрээ, гүнзгийрэлт өөрчлөгдөхгүй ч ядуурлын мэдрэмж нь нэмэгддэг.


8 Хот суурин газарт нийслэл, аймгийн төвийг, хөдөөд сумын төв, хөдөө нутгийг оруулж ойлгоно.

Алслагдсан хөдөө орон нутагт ядуурал илүү их байгаа бөгөөд эдгээр бүс нутагт ядуурлын түвшин 41.2 хувьд хүрээд байна. Суурьшлын дөрвөн төрлөөр авч үзвэл, хөдөө нутгийн ядуурлын түвшин хамгийн өндөр ба сумын төвөөс 10.6 нэгж хувиар, аймгийн төвөөс 15.1 нэгж хувиар, Улаанбаатар хотоос 19.6 нэгж хувиар өндөр байна (Зураг 2.2а). Ядуурлын бусад үзүүлэлтүүдийг авч үзвэл, ядуурлын гүнзгийрэлт хөдөө нутагт хамгийн өндөр буюу 9.0 хувь, ядуурлын мэдрэмж 2.9 хувь байна. Мөн хөдөө нутагт амьдарч буй ядуу хүн амын дундаж хэрэглээ бусад суурьшлын ядуу хүн амын дундаж хэрэглээнээс 2.0-3.3 хувиар доогуур байна (Зураг 2.2а).

Хөдөө ядуурлын түвшин өндөр байгаа ч ядуу хүн амын талаас илүү хувь (56.8 хувь) нь хот суурин газарт амьдарч байна. Ядуу хүн амын дийлэнх нь хот суурин газарт амьдарч байгаа нь Улаанбаатар болон аймгийн төвүүдэд манай улсын нийт хүн амын гуравны хоёр нь амьдардагтай холбон тайлбарлаж болно. Харин ядуу хүмүүсийн 43.2 хувь нь сумын төв болон хөдөө нутагт амьдарч байна (Зураг 2.2б). Хүн ам ихээр суурьшсан хот суурин, ялангуяа Улаанбаатар хотод орон сууц, суурь үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байдаг нь эмзэг байдлыг улам нэмэгдүүлдэг тул ядуу хүн амын төвлөрөл ихтэй хот суурин газрын ядуурлын асуудлыг шийдвэрлэх нь чухал юм.

Зураг 2. 2

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, суурьшлаар, хувиар, 2022



Ядуурлын түвшнийг бүсээр авч үзвэл, Улаанбаатар хот болон Төвийн бүсэд хамгийн бага байна. Улаанбаатар хот (21.6 хувь) болон Төвийн бүс (24.6 хувь)-ийн ядуурлын түвшин улсын дунджаас 2.5-5.5 нэгж хувиар бага, харин Баруун, Зүүн болон Хангайн бүсүүдийн ядуурлын түвшин

улсын дунджаас 6.3-9.4 нэгж хувиар өндөр байна. Хэдийгээр ядуурлын түвшин Баруун бүсэд хамгийн өндөр байгаа ч Зүүн бүсийн ядуурлын гүнзгийрэлт (8.8%), мэдрэмж (3.2%) хамгийн өндөр буюу ядуурлын эрчимжилт их байна (Зураг 2.3а).


Ядуу хүмүүсийн дийлэнх хэсэг Улаанбаатар хот болон Хангайн бүсэд амьдардаг.

Улаанбаатар хотод ядуурлын түвшин бага хэдий ч хүн ам хамгийн их төвлөрсөн бүс нутаг тул ядуучуудын бараг таван хүн тутмын хоёр нь Улаанбаатар хотод амьдарч байна. Мөн

хүн амын төвлөрөл их (Улаанбаатараас бусад бүсүүд дунд)-тэй Хангайн бүсэд ядуучуудын ойролцоогоор дөрөвний нэг нь амьдардаг, харин бага хүн амтай Зүүн бүсэд ядуурлын түвшин өндөр ч ядуучуудын 10 хүрэхгүй хувь нь амьдарч байна (Зураг 2.3б).

Зураг 2.3

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, ядуу хүн амын тархалт, бүсээр⁹, хувиар, 2022



Олон тооны иргэд ядуурлын шугамын дөнгөж дээгүүр хэрэглээтэй амьдарсан хэвээр байгаа нь эдгээр иргэд ядууралд өртөх өндөр эрсдэл байгааг харуулж байна.


Ядуурлын шугам өөрчлөгдөхөд ядуурлын үндсэн үзүүлэлтүүд хэр зэрэг мэдрэмжтэй байгааг ойлгох нь чухал байдаг. Ядуурлын шугамыг 20-н хувиар өсгөхөд нийт хүн амын 13.9 хувь буюу 468.0 мянган хүн ядууралд нэмж өртөх тооцоолол гарсан (Зураг 2.4). Хэрэв нийгэм, эдийн засгийн байдалд ахиц, дэвшил гарахгүй буюу өөрчлөлтгүй байхад үнийн өсөлт, ажилгүйдэл, өвчин, байгалийн гамшиг зэрэг гэнэтийн цочролд эдгээр хүмүүс ядууралд орох эмзэг байдалтай байна гэсэн

үг юм. Харин эсрэгээрээ ядуурлын шугамыг бууруулах тусам ядуу гэж ангилагдах хүн амын тоо аажмаар буурч 20 хувьд хүрэхэд ядуурлын түвшин 14.4 хувь байхаар байна. Эдгээр ядуурлын шугамын ялгавартай түвшнүүдэд ядуу хүн амын тархалтад орж буй өөрчлөлтөөс олон тооны хүн эмзэг байдалтай байгааг харж болно. Тиймээс ядуурлын шугамаас доогуур амьдарч буй хүн амаас гадна ядууралд өртөхөд ойрхон эмзэг өрх, хүн амд чиглэсэн бодлого байх нь чухал юм.

9 Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгууд, Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон аймгууд, Төвийн бүсэд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгууд, Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд багтдаг.

Зураг 2. 4

Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2022



2022 оны байдлаар Жини индекс улсын дунджаар 31.4 нэгж байсан¹⁰ бол хот суурин газарт тэгш бус байдал илүү өндөр байна.

2022 оны байдлаар хүн амын хамгийн чинээлэг 10 хувь нь хамгийн ядуу 10 хувиас дөрөв дахин их хэрэглээтэй байна (Хүснэгт 2.1). Энэхүү улсын түвшний үр дүн нь орон зайн буюу хот, хөдөөгийн хүн амын хоорондын болон тухайн байршлын хүн амын дундах тэгш бус байдал ямар байгаагаас хамаарчээ. Хэрэглээний түвшин хот, хөдөөгийн хүн амын хооронд эрс ялгаатай бөгөөд хот суурин газар, ялангуяа Улаанбаатарын хүн амын дундаж хэрэглээ

хөдөө нутгийн хүн амынхаас 54 хувиар өндөр байна (дараагийн бүлгээс дэлгэрэнгүй харна уу). Эдгээр байршлын ялгаатай байдал нь улсын хэмжээний тэгш бус байдал өндөр гарахад нөлөөлсөн байна. Мөн хотын Жини индекс хөдөөгийнхөөс 6.4 нэгжээр өндөр байгаагаас хотын өрхүүдийн дунд хэрэглээний ялгаатай байдал их буюу илүү олон бүлгийн төлөөлөл бүхий хүмүүс байгааг илтгэж байна. Хэдийгээр Улаанбаатар хотод ядуурлын түвшин бага ч Жини индекс бусад бүсүүдээсээ 4.7-8.1 нэгжээр өндөр байна.

10 Жишсэн насанд хүрсэн хүний хэрэглээ нь өрхийн эдийн засгийн чадамж болон өрх доторх хүүхэд, насанд хүрсэн хүний хэрэглээний ялгаатай байдлыг харгалзан ядуурлыг хэмжихэд ашигласан. Харин нэг хүнд ногдох хэрэглээ нь өрх доторх гишүүдийн бүтцээс үл хамааран хүмүүсийн дундаж бодит нөөцийн хуваарилалт тусгахын тулд тэгш бус байдлыг тооцоход ашигласан. Нэг хүнд сард ногдох хэрэглээ 2022 оны байдлаар 481.4 мянган төгрөг гарсан.

Хүснэгт 2.1 Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, 2022

	Жини индекс	P90/P10 харьцаа
Улсын дундаж	31.4	4.1
Хот	32.3	4.4
Хөдөө	25.9	3.2
Суурьшил		
Улаанбаатар	33.2	4.7
Аймгийн төв	28.7	3.7
Сумын төв	26.3	3.3
Хөдөө нутаг	24.9	3.0
Бүс		
Баруун	25.1	3.1
Хангай	28.1	3.5
Төв	27.0	3.4
Зүүн	28.5	3.7
Улаанбаатар	33.2	4.7

Тайлбар. P90/P10 харьцаа нь хүн амын хамгийн чинээлэг 10 хувь (P90) болон хамгийн ядуу 10 хувь (P10)-ийнхны хэрэглээг харьцуулан тэгш бус байдлыг хэмждэг. Энэ харьцаа нь өндөр байх нь хүн амын дээд болон доод бүлгийн хүн амын дунд хэрэглээний ялгаа өндөр байгааг илэрхийлэх бөгөөд илүү их тэгш бус байдал байгааг илтгэдэг.

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол, ӨНЭЗС 2022

ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ

Тухайн улсын амьжиргааны түвшин, амьдрах өртөг, хэрэглээний онцлогийг тусгаж, ядуурлыг илүү нарийвчлан, үндэсний онцлогийг тусгасан байдлаар хэмжих зорилгоор улс орнууд өөрийн үндэсний ядуурлын шугамыг тодорхойлж, ядуурлыг хэмждэг. Харин Дэлхийн Банкны олон улсын ядуурлын шугамууд¹¹ нь улс орнуудын ядуурлыг хооронд нь харьцуулах, жишиг тогтоох боломжийг олгодог.

Дундаас дээш орлоготой улсын ядуурлын шугам 6.85 доллароор тооцсон Монгол Улсын ядуурлын түвшин 22.1 хувь нь үндэсний ядуурлын түвшинтэй ойролцоо байна. 2017 оны худалдан авах чадварын паритет (PPP)-д суурилсан туйлын ядуурлын шугам болох нэг хүнд хоногт ногдох 2.15 ам.доллар (ХАЧП)-ын түвшинд Монголын ядуурлын хамралт маш бага буюу 0.2 хувь байна. Харин бага дунд орлоготой улсуудын ядуурлын шугам болох 3.65 ам.доллар (ХАЧП)-аар тооцвол ядуурлын хамралт бага зэрэг

өсөж 2.4 хувь байна. Дундаас дээш орлоготой улсын ядуурлын шугам болох 6.85 ам.доллар (ХАЧП)-аар тооцвол ядуурлын хамралт 22.1 хувь байгаа нь Монгол Улсын үндэсний ядуурлын түвшинтэй ойролцоо байна.


Төв болон Зүүн Азийн дундаж орлоготой бусад орнуудтай харьцуулахад Монгол Улсын ядуурлын түвшин дунд, харин тэгш бус байдлаараа илүү доод түвшинд байна. Дундаас дээш орлоготой улсын ядуурлын шугам 6.85 доллароор хэмжихэд Монгол Улсын ядуурлын түвшин Вьетнам, Узбекистан улсуудтай ойролцоо, харин Лаос, Филиппин, Тажикстан зэрэг улсуудаас мэдэгдэхүйц бага түвшинд байна (Зураг 2.5а). Монгол Улсын тэгш бус байдал (Жини индексээр хэмжсэн) нь тэгш бус байдал бага байдаг Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан улс орнууд болох Узбекистан, Казахстан, Тажикстан улсуудын түвшинтэй ойролцоо байна.

¹¹ Олон улсын ядуурлын шугам нь нэг хүнд ногдох өдрийн хэрэглээнд суурилан тооцдог. Энэ нь бусад улс орнуудын ядуурлын үзүүлэлтүүдийг харьцуулах боломжийг олгодог.

Зураг 2. 5

Ядуурлын хамралтын хүрээ, 2017 оны ХАЧП-аар тооцсон 6.85 ам.долларын ядуурлын шугамаар, Жини коэффициент

а) Ядуурлын хамралтын хүрээ, улс орнуудаар, хувиар



б) Жини коэффициент, улс орнуудаар





БҮЛЭГ:

3



ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ 2022 ОНД

Энэ бүлэгт хүн амын хэрэглээний хэв шинж, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөрөнгийн эзэмшил, суурь үйлчилгээний хүртээмж зэрэг үзүүлэлтүүдээр 2022 оны ядуурлын дүр төрхийг харууллаа.

3.1. Ядуурал, хэрэглээний хэв шинж


Жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ 658.0 мянган төгрөг байна. Бүлэг 1-д дурдсанчлан, өрхийн хэрэглээ нь хүнс, хүнсний бус, сууц болон удаан эдэлгээтэй бараа гэсэн үндсэн дөрвөн бүрэлдэхүүнээс бүрддэг. 2022 оны байдлаар жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээний 29.5 хувийг хүнс, 41.7 хувийг хүнсний бус, 16.1 хувийг сууц, 12.6 хувийг удаан эдэлгээт бараа, бүтээгдэхүүний хэрэглээ бүрдүүлж байна.

Ядуу бус хүн амын жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ ядуу хүн

амынхаас 2.5 дахин их байна. Судалгааны 2022 оны дүнгээр ядуу бус жишсэн насанд хүрсэн нэг хүн сард дунджаар 784.0 мянган төгрөгийг хэрэглээндээ зарцуулдаг бол ядуу хүн 318.0 мянган төгрөг буюу өдөрт дунджаар 10,456 төгрөгийг зарцуулж байна (Зураг 3.1а). Хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхан сард дунджаар 1.25 сая төгрөгийг хэрэглээндээ зарцуулсан нь дунджаар 290.0 мянган төгрөгийн хэрэглээтэй хамгийн ядуу бүлгийн хүн амынхаас 4.3 дахин байна. Энэ нь хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээ улсын нийт хэрэглээнд харьцангуй давамгайлж, нийт хэрэглээний 39 хувийг эзэлж байгаа бол хамгийн ядуу 20 хувийнхны хэрэглээ дөнгөж 8 хувийг эзэлж байна.

Зураг 3.1

Жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, хэрэглээний тархалт, тэнцүү 5-н бүлгээр, 2022



Хэрэглээний тархалтаас харахад өрхүүд хүнсний бус бараа, үйлчилгээ (удаан эдэлгээтэй бараа болон сууцны хэрэглээг оруулсан)-нд хүнстэй харьцуулахад илүү зардал гаргадаг байна. Улсын дунджаар нийт

жишсэн насанд хүрсэн нэг хүн дунджаар нийт хэрэглээнийхээ 70 хувь буюу 464.0 мянган төгрөгийг хүнсний бус бараа, үйлчилгээнд зарцуулдаг. Харин 194.0 мянган төгрөг буюу 30 хувийг хүнсэндээ зарцуулдаг байна.


Хүн амын амьжиргаа доогуур байх эсвэл чинээлэг байхаас үл хамаараад хүнсний бус бараа, үйлчилгээнд хүнстэй харьцуулахад илүү зардал гаргадаг ч амьжиргаа доогуур бүлгийнхний нийт хэрэглээнд эзлэх хүнсний зардлын хувь чинээлэг бүлгийнхээс илүү өндөр байна. Тухайлбал, хэрэглээний бүлгийн хамгийн ядуу 20 хувьд амьдардаг хүмүүс нийт хэрэглээнийхээ 43 хувийг хүнсэндээ зарцуулдаг бол хамгийн чинээлэг 20 хувь нь 23 хувийг хүнсэндээ зарцуулжээ.

Нийт хэрэглээнд хүнсний бус бараа, үйлчилгээний хэрэглээ дийлэнх хувийг эзэлж байгаа ч удаан эдэлгээтэй бараа болон сууцны хэрэглээ нь хүн амын амьжиргааны ялгааг харуулж буй гол хүчин зүйл болж байна. Хүн

амын ялгаатай бүлгүүдэд хүнсний бус бараа, үйлчилгээ (удаан эдэлгээтэй бараа, сууны хэрэглээ ороогүй)-ний хэрэглээний нийт хэрэглээнд эзлэх хувь хэлбэлзэл хамгийн бага буюу 39-44 хувийн хооронд байна (Зураг 3.2б). Харин хамгийн чинээлэг 20 хувийнхны удаан эдэлгээтэй бараа болон сууцны хэрэглээ хамгийн ядуу бүлгийнхээс дунджаар 11 дахин их байна (Зураг 3.2а). Тухайлбал, хамгийн ядуу бүлгийн жишсэн насанд хүрсэн нэг хүн сард дунджаар сууцандаа 19.3 мянган төгрөг, удаан эдэлгээтэй бараанд 22.2 мянган төгрөг зарцуулдаг бол хамгийн чинээлэг бүлгийн сууцны хэрэглээ 13 дахин их буюу 258.3 мянган төгрөг, удаан эдэлгээтэй барааны хэрэглээ 9 дахин их буюу 196.4 мянган төгрөг байна.

Зураг 3. 2

Жишсэн насанд хүрсэн нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ, хэрэглээний үндсэн бүрэлдэхүүний бүтцээр, 2022



Ядуу болон хөдөөгийн өрхийн хувьд хүнсний хэрэглээний төрөлжилт хангалттай бус байна. Нэг хүний хүнсний зардлын 70 хувь нь мах, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүнүүдээс бүрдэж байна. Мөн ядуу хүмүүс хүнсний

хэрэглээнийхээ 81 хувийг эдгээр хүнсний нэр төрлүүдэд зарцуулж байгаа нь цөөн тооны хүнсний төрөл зүйл хэрэглэгддэг нь харагдаж байна. Харин ядуу бус хүмүүс эдгээр хүнсний нэр төрлүүдэд нийт хүнсний хэрэглээний 68


хувийг зарцуулжээ. Хотын ядуу бус өрхүүдийн махны хэрэглээ ядуу өрхүүдээс харьцангуй бага байгаа нь дээрх зөрүү үүсэх шалтгаан болсон.

Амьжиргааны түвшин сайтай өрхүүд илүү гадуур хооллох хэв маягтай болсон байна.

Ядуу бус өрхүүд хүнсний хэрэглээнийхээ дунджаар 11 хувийг гэрээсээ гадуур хооллоход зарцуулдаг (Зураг 3.3). Энэ хандлага нь хотын ядуу бус өрхийн хувьд харьцангуй өндөр буюу ойролцоогоор 14.5 хувь байхад хөдөөгийн ядуу бус өрхийнх дөнгөж 1.4 хувь байна. Энэ

нь хотын амьдралын хэв маягтай холбоотой байх магадлалтай. Ихэнх хүмүүс гэрээсээ хол зайтай ажилладаг тул урт хугацаанд зорчих шаардлага үүсдэг. Үүнээс гадна ажлын ачаалал ихтэй байх, ресторан, хоолны газруудын хүртээмжтэй байх, мөн хүмүүс тав тухыг эрхэмлэх, ресторан, гудамжны хоол, бэлэн бэлтгэсэн хоол, хүнс хэрэглэхийг илүүд үздэг болох зэрэг соёлын өөрчлөлтүүд нь хотын ядуу биш хүн амын дунд гадуур хооллох үзэгдлийг түгээмэл болгож байх боломжтой.

Зураг 3.3 Өрхийн сарын дундаж хүнсний хэрэглээ, хүнсний хэрэглээний бүтэц, ядуурлын байдлаар, 2022



Хүнсний бус хэрэглээний зардлууд дотроос хувцас болон тээврийн зардал хамгийн өндөр хувийг эзэлдэг бөгөөд ядуу болон ядуу бус өрхийн нийт хүнсний бус хэрэглээний бараг 40 хувийг бүрдүүлдэг. Жишсэн насанд хүрсэн нэг хүний хүнсний бус бараа, үйлчилгээний дундаж хэрэглээ сард 275,0 мянган төгрөг байдаг бөгөөд үүний бараг 20 хувийг бэлэн хувцас, 18 хувийг тээвэр, тээврийн


үйлчилгээний зардал эзэлдэг (Зураг 3.4). Бусад онцлох зардлуудыг авч үзвэл түлш, эрчим хүч, сууцны төлбөрт 11.2 хувийг, хувь хүнд хандсан бараа, үйлчилгээнд 10.6 хувийг, эрүүл мэндэд 9.7 хувийг зарцуулжээ.

Хүн амын хэрэглээний ялгаатай бүлгүүд хооронд хүнсний бус хэрэглээний бүтэц ихээхэн ялгаатай байдаг. Ядуу өрхүүд ядуу

бус өрхүүдтэй харьцуулахад хувцас болон түлш, эрчим хүч, сууны төлбөрт илүү зардал гаргадаг ба боловсрол, эрүүл мэнд зэрэг зайлшгүй шаардлагатай үйлчилгээнд бага зардалгаргадаг байна. Жишсэн насанд хүрсэн нэг хүнд сард ногдох хүнсний бус хэрэглээнд хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхан нь хамгийн ядуу 20 хувийнхантай харьцуулахад 4 дахин их мөнгө зарцуулжээ. Хамгийн илэрхий өндөр ялгаа нь боловсролын зардалд ажиглагдах бөгөөд хамгийн чинээлэг бүлгийн өрхийн нийт хүнсний бус хэрэглээнийхээ 9.5 хувийг боловсролд зарцуулдаг бол хамгийн ядуу бүлгийнхэн ердөө 3.7 хувийг зарцуулдаг (Зураг 3.4). Харин ядуу өрхүүдийн хувьд хүнсний бус хэрэглээнд хувцас, түлш, эрчим хүч, сууцны төлбөр илүү өндөр хувийг эзэлдэг. Энэ нь тэдний урт хугацааны хүний капиталын хөрөнгө оруулалтаас илүүтэйгээр өдөр тутмын амин чухал хэрэгцээгээ хангахад анхаардаг болохыг харуулж байна.

Хөдөө болон хотын ядуу өрх хооронд тодорхой ялгаанууд байдаг нь тодорхой бүс нутагт чиглэсэн бодлого боловсруулах шаардлагатайг харуулж байна. Хотын ядуу өрхүүдийн хувьд түлш, эрчим хүч, сууцны төлбөрийн зардал нь томоохон дарамт болж, нийт хүнсний бус хэрэглээний тавны нэгийг эзэлдэг байна (Зураг 3.4). Харин хөдөө орон нутгийн ядуу өрхүүд хүнсний бус зардлынхаа ихэнх хувийг хувцас, тээврийн зардалд зарцуулдаг бөгөөд эдгээр бараа, үйлчилгээнд нийт хүнсний бус хэрэглээнийхээ бараг талыг зарцуулдаг. Эдгээр хэрэглээний хэв маяг нь хот, хөдөөгийн ядуу өрхүүдийн тулгарч буй бэрхшээлийг тодотгож, ядуурлыг үр дүнтэй бууруулахын тулд бүс нутгийн онцлогт тохирсон бодлого хэрэгжүүлэхийн чухлыг харуулж байна.

Зураг 3.4 Өрхийн сарын дундаж хүнсний бус хэрэглээ, хүнсний бус хэрэглээний бүтэц, ядуурлын байдлаар, 2022




3.2. Өрхийн хүн ам зүйн шинж чанарууд

Ам бүл цөөтэй, ялангуяа хүүхэдгүй эсвэл цөөн хүүхэдтэй өрхүүд ядуу байх магадлал бага байна. Манай улсын нэг өрх 2022 онд дунджаар 3.4 ам бүлтэй, үүнээс ядуу бүлэгт хамаарах өрхүүдийн ам бүлийн дундаж 4.2, ядуу бус өрхүүдийн ам бүлийн дундаж 3.2 байна (Зураг 3.5а). Хэрэглээний ялгаатай бүлгүүдэд өрхийн ам бүлийн дундаж тоо өөр байна. Тухайлбал, хамгийн ядуу 20 хувийн өрхийн ам бүлийн дундаж хамгийн чинээлэг хувийнхны ам бүлийн дунджаас ойролцоогоор 1.5 дахин их, 0-14 настай хүүхдийн дунджаас 2.2 дахин их байна.

Хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээлгэгчдийн тоо болон хүүхдийн тоо ихсэх тусам ядуурал нэмэгдэж байна. Өрхийн гишүүдийн насны бүтэц нь ядуурлыг тодорхойлох нэг үзүүлэлт юм. Ядуу өрх олон

хүүхэдтэй байгаа нь хүн ам зүйн ачаалал¹² нэмэгдэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, ядуу өрхөд өрхийн бусад гишүүдээ, ялангуяа үр хүүхдүүдээ тэжээн тэтгэх хангалттай тооны хөдөлмөрийн насны хүмүүс дутагдалтай байгааг харуулж байна. Үүний үр дүнд ядуу өрх ядуу бус өрхтэй харьцуулахад нэг хүнд ногдох орлого бага байдаг. Ядуу өрхийн хүн ам зүйн ачаалал дунджаар ядуу бус өрхийнхөөс 22.6 хувиар өндөр буюу ядуу өрхийн хөдөлмөрийн насны 100 хүнд ядуу бус өрхтэй харьцуулахад 14 тэжээлгэгч илүү ногдож байна (Зураг 3.5б). Ядуу өрхүүдийн хувьд асрамж шаардлагатай хүн ам болох хүүхдийн тоо их, харин чинээлэг өрхүүдийн хувьд өндөр настан их байдаг нь голчлон хүн ам зүйн ачаалал ялгаатай гарахад нөлөөлжээ. Хэрэглээний ялгаатай бүлгүүдээр авч үзвэл, хүүхдийн ачаалал эрс буурч байгаа нь нийт хүн ам зүйн ачаалал чинээлэг бүлэгт бага гарахад нөлөөлсөн байна.

Зураг 3.5 Өрхийн ам бүлийн дундаж тоо, хүн ам зүйн ачаалал, 2022



¹² Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох "тэжээлгэгчдийн" хувийг илэрхийлдэг. Хүн ам зүйн ачаалал нь өрхийн хөдөлмөрийн бус насны гишүүд (15 хүртэлх насны хүүхдүүд болон 65, түүнээс дээш насны хөгшдийн тоо)-ийн тоог хөдөлмөрийн нас (15-64 нас)-ны гишүүдийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Өрхөд хүүхдийн тоо их байх нь илүү өндөр ядууралтай байх хандлага ажиглагдаж байна. Нийт өрхийн ойролцоогоор 60 орчим хувь нь хүүхэдтэй ба тэдгээрийн ядуу байх магадлал хүүхэдгүй өрхтэй харьцуулахад 12 нэгж хувиар өндөр байна (Зураг 3.6а). Нэг өрхөд 1 хүүхэд нэмэгдэх нь ядууралд өртөх магадлалыг дунджаар 6.4 нэгж хувиар нэмэгдүүлдэг. Тиймээс улсын хэмжээнд

ядуурлын түвшин 27 хувь байгаа ч 15-аас доош насныхны ядуурлын түвшин 31-33 хувьтай байна (Зураг 3.6б). Эсрэгээрээ ахмад настай хүмүүс илүү чинээлэг өрхөд амьдрах магадлал өндөр байгаа ба энэ нь эрүүл мэндийн үйлчилгээнд илүү хамрагддаг, тогтмол тэтгэврийн орлоготой байх гэх мэт нь нөлөөлж, ядуурал харьцангуй бага гарсан байх боломжтой.

Зураг 3.6 Ядуурлын хамралтын хүрээ, насны бүлэг, хүүхдийн тоогоор, 2022



3.3. Боловсрол

Боловсролгүй эсвэл бага боловсролтой хүн мэргэжлийн ур чадвар шаардахгүй ажил буюу цалин багатай ажил хийж, цаашлаад ядууралд илүү өртөмтгий болдог. Боловсролын түвшин өндөр байх нь ажилд орох боломжуудыг нэмж өгөхөөс гадна нийгэмдээ илүү идэвхтэй оролцоотой байх зэрэг аж байдлын бусад чухал талуудыг нээхэд тусалдаг. Тиймээс хүн

амын амьжиргааны түвшинг сайжруулах нэг чухал хүчин зүйл нь боловсролын асуудал гэж үзэж болно.

Ядуу болон ядуу бус хүн амын боловсролын түвшингийн ялгаа дээд боловсрол эзэмшсэн байдлаар илүү тодорхой харагдаж байна.


Ядуу 25, түүнээс дээш насны арван хүн тутмын нэг нь дээд боловсролтой байгаа нь улсын түвшинд 32 хувь, ядуу бус хүн амын

дунд 39 хувь байгаагаас мэдэгдэхүйц доогуур түвшин юм (Зураг 3.7а). Чинээлэг бүлгийн хүн амын дунд дээд боловсрол эзэмших хандлага мэдэгдэхүйц өндөр байгаа нь хүн амын аж байдалтай эзэмшсэн боловсролын түвшин хүчтэй хамааралтай байгааг илтгэж байна. Боловсролгүй хүн амын хувьд ядуурлын

түвшин хамгийн өндөр буюу 51 хувьтай байгаа бол дээд боловсролтой хүн амын 7 хувь нь ядуу байна (Зураг 3.7б). Боловсрол болон ядуурлын хамаарал нь сайн боловсрол эзэмших нь тухайн хүний ирээдүйн амьдралд эерэг нөлөө үзүүлэх хамгийн том хөрөнгө оруулалт болохыг илэрхийлж байна.

Зураг 3.7

25, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, ядуурлын хамралтын хүрээ, 2022



Ядуу өрхүүдийн хүүхдүүд илүү хожуу суралцаж эхэлдэг ба сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нь чинээлэг өрхүүдийн хүүхдүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц бага түвшинтэй байна. Хамгийн чинээлэг 20 хувийн өрхийн 2-6 настай хүүхдүүдийн 63 хувь нь сургуулийн өмнөх боловсролд (СӨБ) хамрагдаж байгаа бол хамгийн ядуу 20 хувийнхны хувьд энэ үзүүлэлт 45 хувьтай байна. Энэ ялгаа нь танин мэдэхүйн болон нийгмийн хөгжлийн талаасаа чухал ач холбогдолтой, урт хугацаандаа боловсрол, ирээдүйн боломжуудад нөлөө үзүүлдэг бага насны хүүхдийн боловсролд тэгш бус

хүртээмжтэй хамрагдаж байгааг харуулж байна. Алслагдсан хөдөө орон нутгийн хүүхдүүд боловсролын байгууллага тэдний амьдарч буй газраас хол зайд байгаагаас шалтгаалан сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг. Энэхүү газар зүйн саад бэрхшээл нь бага насны хүүхдийн боловсрол эзэмших боломжийг улам бүр хязгаарлаж, ядуу, тусгаарлагдсан өрхийн хүүхдүүдэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг улам нэмэгдүүлж байна.


Мөн ядуу өрхийн хүүхдүүд илүү төрийн өмчийн сургуульд суралцаж байгаа бол өрхүүдийн амьжиргааны түвшин ахих тусам хувийн сургуульд хамрагдах хандлага нь их байна. Тухайлбал, хамгийн чинээлэг 20 хувийн өрхийн бараг дөрвөн хүүхэд тутмын нэг нь ерөнхий боловсрол олгох хувийн сургуульд суралцаж байгаагаас харагдана. Харин хамгийн ядуу өрхийн хүүхдүүдийн нэг хувь хүрэхгүй хүүхдүүд хувийн сургуульд сурдаг нь

эдгээр өрхүүдийн санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбон тайлбарлаж болох юм. Амьжиргаа сайтай хүмүүс хүүхдүүдээ хувийн сургуульд сургах хандлага нэмэгдэж байгаа нь тухайн хүүхдийн сурлагын амжилт гаргах, нийгмийн харилцаанд оролцох зэргээр илүү боломжууд гарч ирэх бол ядуу өрхийн хүүхдүүдийн хувьд сул тал болж, цаашдаа тэгш бус байдал улам гүнзгийрэх юм.


Зураг 3. 8

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, бага сургуулийн төрлөөр, хувиар, 2022

а) СӨБ-д хамрагдалт (2-6 нас), хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, сууршлаар, хувиар



б) Хувийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, хувиар



Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол, ӨНЭЗС 2022

3.4. Хөдөлмөр эрхлэлт

Хүн амын ядуурал, аж байдлыг тодорхойлогч өөр нэг чухал хүчин зүйл бол хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрхэлж байгаа ажлын төрөл юм. Тогтвортой, өндөр цалинтай ажлын байр нь өрхүүдийг үндсэн хэрэгцээгээ хангах, боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах, эдийн засгийн тогтвортой байдлаа бэхжүүлэх боломжийг олгодог. Харин албан бус, бага цалинтай, тогтворгүй ажил эрхлэлт


нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, өрхүүдийн амьжиргаа дээшлүүлэх боломжийг хязгаарладаг.

2022 онд ядуу хүмүүс, ялангуяа хотын ядуу иргэд, орлого олох үйл ажиллагаанд оролцох магадлал нь ядуу бус хүмүүстэй харьцуулахад мэдэгдэхүйц бага байсан. Хөдөлмөрийн нас (15, түүнээс дээш)-ны хүн амын дунд ядуу хүмүүс ажил эрхлэх магадлал ядуу бусаас 10.1 нэгж хувиар бага байна

(Зураг 3.9а). Үүний оронд, тэд хөдөлмөрийн зах зээлд идэвхгүй байх эсвэл ажилгүй¹³ байх хандлагатай байжээ. Энэ нь тогтвортой ажил эрхлэх боломжид саад тулгарч байгааг харуулж байна. Энэхүү ялгаа нь хот, суурин газарт илүү тод илэрдэг. Учир нь хотод хөдөлмөр эрхлэлтийн түвшин ерөнхийдөө бага байдаг. Харин хөдөө орон нутагт хөдөө аж ахуй, мал аж ахуйн хувиараа хөдөлмөр эрхлэлт өндөр байдаг тул ядуу болон ядуу бус хүмүүсийн ажиллах хүчний оролцоо харьцангуй бага зөрүүтэй байна. Хотод энэ зөрүү 14.8 нэгж хувьтай байгаа нь хотын ядуу иргэд ажил олох, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэхэд илүү их бэрхшээлтэй тулгарч байгааг илтгэж байна.

Ажилгүй байх нь ядууралд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Өрхийн тэргүүн нь ажилгүй байгаа өрхүүдийн ядуурлын түвшин 46.2 хувь бөгөөд энэ нь ажил эрхэлдэг эсвэл хөдөлмөрийн зах зээлд идэвхгүй¹⁴ (ажиллах хүчнээс гадуур) оролцдог өрхүүдийнхээс хавьгүй өндөр үзүүлэлт юм (Зураг 3.9б). Энэхүү ялгаа нь ажил эрхлэлт нь тодорхой хэмжээний эдийн засгийн тогтвортой байдлыг хангадаг ч ажил хөдөлмөрийн төрөл болон тогтвортой байдал нь маш чухал болохыг харуулж байна. Учир нь чанаргүй эсвэл албан бус хөдөлмөр эрхлэлт нь өрхүүдийг ядуурлын эрсдэлд байлгасаар байна.

Зураг 3.9 Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар, 2022




13 Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ.

14 Хөдөлмөрийн зах зээлд идэвхгүй өрхийн тэргүүнтэй өрхүүд ядуурлын түвшин өндөртэй байдаг ч энэ нь ажилгүй өрхүүдийнхээс бага түвшинд байна. Учир нь идэвхгүй хүмүүс ихэвчлэн тэтгэвэр авагчид байдаг бөгөөд тэтгэвэр эсвэл бусад санхүүгийн дэмжлэг авах боломжтой байдаг.

Ядуу болон ядуу бус ажилчид ялгаатай салбаруудад хөдөлмөр эрхэлдэг бөгөөд ядуу хүмүүс хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуй болон амьтны гаралтай үйлдвэрлэлд ихэвчлэн оролцдог байна. Ядуу хүмүүсийн ойролцоогоор дөрвөн хүн тутмын нэг нь хөдөө аж ахуйд ажилладаг бөгөөд энэ нь ядуу бус ажилчдын тус салбарт ажилладаг түвшинтэй харьцуулахад хоёр дахин их дүн юм (Зураг 3.10). Хөдөө аж ахуйд илүү өндөр оролцоотой байдал нь орон зайн ялгааг харуулж байгаа бөгөөд ядуу хүмүүс хөдөө орон нутагт, ялангуяа алслагдсан хөдөө нутагт амьдрах хандлага өндөр, энд хөдөлмөр эрхлэлт нь ихэнхдээ хөдөө аж ахуйн салбарт төвлөрсөн

байдагтай холбоотой юм. Хөдөө аж ахуйд ажиллаж буй хүмүүсийн хувь хэмжээ хүн амын хэрэглээний бүлгүүдээр харьцуулж үзвэл, амьжиргааны түвшин сайжрах тусам эрс буурдаг бөгөөд хамгийн чинээлэг 20 хувийнхны зөвхөн 6 хувь нь хөдөө аж ахуйд ажилладаг. Амьжиргааны түвшин сайжирч, хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хөдөлмөр эрхлэлт хөдөө аж ахуйн салбараас өндөр ур чадвартай уул уурхай, мэргэжлийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарууд руу шилжиж байна. Энэ нь эдийн засгийн өөрчлөлт болон өндөр цалинтай ажил олох боломжууд нэмэгдэж байгааг харуулж байна.

Зураг 3. 10 Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, 2022



Ядуу ажилчид бага ур чадвар шаарддаг, мөн албан бус салбарт хөдөлмөр эрхлэх магадлал өндөр байна. Ядуу ажилчдын дийлэнх нь (59 хувь) цалин хөлстэй буюу тогтмол орлоготой ажил эрхэлдэг ч ядуу бус ажилчдынхаас 14 нэгж хувиар бага байна (Зураг 3.11а). Харин эдгээр хүмүүс илүү


хувиараа хөдөлмөр эрхэлдэг ба голчлон мал аж ахуй эсвэл өрхийн бизнест цалин хөлсгүй ажиллах нь илүү байна. Мөн ядуу ажилчид ур чадвар бага шаардсан буюу энгийн ажил эрхэлдэг бол чинээлэг ажилчид илүү өндөр ур чадвартай ажлуудад, жишээ нь; менежерийн болон мэргэжлийн албан

тушаалд ажиллах хандлагатай байна (Зураг 3.11б). 2022 онд хамгийн чинээлэг бүлгийн ажилчид хамгийн ядуу бүлгээс бараг 8 дахин өндөр магадлалтайгаар менежер эсвэл


мэргэжлийн ажлуудад ажиллаж байна. Энэ нь ур чадвар шаардсан, чанартай ажил эрхлэх нь амьжиргааны түвшинтэй хүчтэй хамаарал байгааг харуулж байна.

Зураг 3. 11 Хөдөлмөрийн насны ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажил мэргэжил, 2022

а) Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар



б) Ажиллагчдын ажил мэргэжлийн төрөл, хувиар




Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол, ӨНЭЗС 2022

Ядуу болон ядуу бус ажилчдын хооронд цалингийн томоохон ялгаа байдаг бөгөөд эдгээр ялгаанууд нь ур чадвар, боловсрол болон ямар салбарт хөдөлмөр эрхэлж байгаа зэргээр ялгаатай тайлбарлагддаг.

2022 онд ядуу ажилчдын дундаж жилийн цалин¹⁵ 6.5 сая төгрөг байсан бол ядуу бус ажилчдын дундаж жилийн цалин 11.8 сая төгрөг байгаа нь бараг хоёр дахин их зөрүү юм. Энэ ялгааг амьжиргааны бүлгүүдийн хувьд авч үзвэл, илүү мэдэгдэхүйц өндөр байна. Тухайлбал, хамгийн ядуу 20 хувийн ажилчид дунджаар 6.1 сая төгрөгийн цалинтай байсан бол хамгийн чинээлэг 20 хувийн ажилчид 15.6 сая төгрөгийн цалинтай байсан нь 2.5 дахин их зөрүү юм. Ур чадвар,

ажил мэргэжил болон салбарын ялгаанууд эдгээр цалингийн ялгаанд чухал нөлөө үзүүлдэг ч, ижил боловсрол, ажил мэргэжил, эсвэл ижил төрлийн салбарт ажиллаж буй хүмүүсийн хүрээнд ч тодорхой ялгаанууд хэвээр байна. Энэ дүгнэлтээс хөдөлмөрийн зах зээлд системийн тэгш бус байдал байгааг, энэ нь ядуу хүмүүст илүү сөргөөр нөлөөлж, эдийн засгийн нөхцөл байдлаа сайжруулах эсвэл илүү сайн нөхцөлтэй ажлын байр, өндөр орлоготой болох зэрэгт хүндрэл учруулж байна. Үндсэндээ тэдний хөдөлмөрийн зах зээл дээр ахиж, дэвших боломжийг хязгаарладаг зэрэг олон саад бэрхшээлүүд байна.

Зураг 3. 12 Цалин хөлстэй ажиллагчдын жилийн дундаж цалин хөлсний орлого, сая төгрөгөөр, 2022




15 ӨНЭЗС-ны 2022 оны мэдээллийн баазаас тооцсон жилийн дундаж цалин нь судалгаанд хамрагдахаас өмнөх сүүлийн 12 сарын хугацаанд хийсэн ажлын бүх цалин хөлс, үүнд тухайн ажилчны хөдөлмөрийн хөлс, урамшуулал, нэмэгдэл (бэлэн мөнгөөр буюу мөнгөн бус урамшууллын хэлбэрээр авсан) зэргийг оруулж тооцсон нийт мөнгөн дүн юм. Зарим хүмүүсийн хувьд сүүлийн 12 сарын тодорхой хугацаанд хөдөлмөр эрхэлсэн бол тухайн хугацааны цалин хөлсний орлого жилийн цалингаар тооцогдоно.

3.5. Өрхийн удаан эдэлгээтэй бараа, санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө эзэмших нь айл өрхийн санхүүгийн тогтвортой, уян хатан байдлын үндэс суурь болж, өрхийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Газар, мал, тоног төхөөрөмж, хуримтлал гэх зэргээр ямар нэг хөрөнгийг эзэмших нь өрхүүд орлого олж, үр өгөөжтэй бизнест хөрөнгө оруулж, цаг хугацааны явцад баялагийг бий болгох боломжтой юм. Хөрөнгө нь мөн эдийн засгийн цочролыг даван туулах, аливаа эрсдэлийг удирдах, орлогын улирлын хэлбэлзэл, ялангуяа хөдөө аж ахуйн салбарын эмзэг байдлыг бууруулах боломжийг олгодог. Тиймээс хөрөнгийн эзэмшил нь урт хугацааны сайн сайхан байдлын чухал хүчин зүйл юм.

Ядуу өрхүүдэд санхүүгийн боломжийг нэмэгдүүлэх хөрөнгө бага байгаа нь ядуу өрхүүдийн амьдрах нөхцөл ядуу бус өрхүүдээс ихээхэн ялгаатай байгааг харуулж байна. Амьжиргааны ялгаатай бүлгүүдэд хөргөгч, өнгөт зурагт зэрэг өргөн хэрэглээний гэр ахуйн эд хогшилтой байх хандлага ижил байдаг (Зураг 3.13). Харин бүтээмжийг нэмэгдүүлдэг, ашиглахад хялбар, цаг хугацаа хэмнэсэн суудлын машин, угаалын машин гэх мэт цахилгаан бараануудыг эзэмшдэг байх нь нэлээдгүй ялгаатай байна. Тухайлбал, чинээлэг 20-н хувийн өрхүүд ядаж нэг суудлын машинтай байх магадлал хамгийн ядуу 20-н хувийнхнаас дөрөв дахин их байна. Харин эрс тэс уур амьсгалаас шалтгаалан ашиглахад хэцүү ч гэсэн ядуу өрхүүдийн хувьд мотоциклтой байх магадлал илүү өндөр байна.

Зураг 3. 13 Өрхийн удаан эдэлгээтэй хөрөнгө, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, хувиар, 2022



Алслагдсан хөдөө нутагт амьдардаг иргэд болон ядуу хүмүүст технологи ашиглах боломж хязгаарлагдмал ба цаашлаад мэдээлэл олжавах, эдийн засаг, боловсролоо дээшлүүлэх боломж бага байна. Гар утас эзэмших байдал хүн амын дунд элбэг байдаг ч амьжиргааны бүлгийн хувьд авч үзвэл гар утас эзэмшдэг хамгийн ядуу бүлгийн хүн ам хамгийн чинээлэг бүлгийнхээс 14


нэгж хувиар бага байна (Зураг 3.14). Мөн ядуу өрхүүдийн дунд интернэтийн хүртээмж, компьютерын хэрэглээ, ашиглалт бага хэвээр байна. 2022 онд хамгийн ядуу бүлгийн өрхийн дөнгөж хоёр хувь нь компьютертой, дөрвөн өрх тутмын нэг нь интернэтэд холбогдсон, харин хамгийн чинээлэг бүлгийн өрхүүдийн арван хүн тутмын бараг найм нь интернэтэд холбогдсон байна. Энэ ялгаатай байдал нь

алслагдсан хөдөө нутаг цахим дэд бүтэц хязгаарлагдмал, холболт сул, төхөөрөмжүүд өрхүүдийн орлоготой харьцуулахад үнэтэй байдагтай холбоотой байж болох юм. Ядуу өрхүүд илүү алслагдсан хөдөө орон нутагт амьдарч байдаг тул цахим төхөөрөмжүүдийг

ашиглах боломж бага байна. Энэ нь одоогийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээний хүртээмжийн ялгаатай байдлыг илүү нэмэгдүүлж, эцэстээ хот, хөдөөгийн цахим хүртээмжийн ялгааг гүнзгийрүүлж байна.

Зураг 3. 14


Өрхийн гар утас, компьютер, интернэтийн хүртээмж, хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, хувиар, 2022



Зээлийг ядуу болон ядуу бус бүх өрхүүд авах боломжтой ч зээлийн зориулалт болон өрхийн аж байдалд үзүүлж буй оролцоог авч үзвэл ихээхэн ялгаатай байна. 2022 оны байдлаар нийт өрхийн ойролцоогоор 55.0 хувь нь ямар нэг төрлийн зээлтэй байна. Ядуу бус өрхийн хувьд зээл авах магадлал ядуу өрхүүдээс бага зэргийн илүү буюу ойролцоогоор 2.5 нэгж хувиар өндөр байна. Зээлийн дийлэнх нь албан ёсны санхүүгийн байгууллагаар дамжуулан авсан зээл ба эх үүсвэр нь ядуу, ядуу бус өрхүүдийн хооронд зөрүү багатай. Харин авсан зээлийн төрлийн хувьд ихээхэн ялгаатай байна. Ядуу өрхүүдийн хувьд тэтгэвэр, малчны зээлийг¹⁶ илүү авдаг

бол чинээлэг өрхүүд орон сууц, бизнесийн зээлийг их авсан байна (Зураг 3.15). Ипотекийн зээл барьцаа хөрөнгөтэй, зээлийн урт түүхтэй чинээлэг өрхүүдэд илүү хүртээмжтэй байна. Зээлтэй хамгийн чинээлэг бүлгийн таван өрх тутмын нэг нь ипотекийн зээлтэй бол хамгийн ядуу бүлгийнх бараг 1 хувь хүрэхгүй байна. Энэхүү ялгаа нь ядуу өрхүүдэд тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг тодотгон харуулж байгаа ба тэдний зээл авах гол зорилго нь урт хугацааны хөрөнгө, баялаг хуримтлуулах биш харин богино хугацааны хэрэгцээг хангахад чиглэгддэг байна.

16 Тэтгэврийн зээл гэдэг нь арилжааны банкууд тэтгэвэр авагчийнхаа ирээдүйн тэтгэврийг барьцаалан олгосон хэрэглээний зээл юм. Малчны зээл нь малчдын амьжиргааг дэмжих зорилгоор олгож буй зээл юм. Цалингийн зээл гэдэг нь ажилчдын цалингийн суутгалаар эргэн төлөгдөх боломжтой бэлэн мөнгөний урьдчилгаа зээл юм.


Зураг 3. 15 Зээлтэй өрхийн эзлэх хувь, зээлийн төрлөөр, 2022

3.6. Орон сууц, суурь үйлчилгээний хүртээмж

Орон сууц, дэд бүтэц буюу цэвэр ус, ариун цэврийн байгууламж, цахилгаан, дулаан зэрэг суурь үйлчилгээний хүртээмж нь эрүүл мэнд, аюулгүй байдал, амьжиргааны түвшинд шууд нөлөөлдөг тул сайн сайхан байдлын үндэс суурь юм. Орон сууцны хүрэлцээ муу, суурь дэд бүтцийн хүртээмж хязгаарлагдмал байх нь өрхүүдийг эрүүл мэндийн эрсдэл, амьжиргааны өртөг нэмэгдээд зогсохгүй боловсрол, хөдөлмөр эрхлэлт, зах зээлд оролцох боломжийг хязгаарласнаар ядуурлыг нэмэгдүүлдэг.

Хотын болон хөдөөгийн ядуу өрхүүд ихэвчлэн гэрт амьдардаг бөгөөд ихэнхдээ найдвартай эрчим хүчний эх үүсвэрээр хангагдах боломж хязгаарлагдмал байдаг. Орон сууцны төрөл нь ядуурлыг тодорхойлох гол хүчин зүйлийн нэг бөгөөд ядуу хүмүүсийн дийлэнх нь гэрт амьдардаг ба ядуу бус хүмүүсээс 42 нэгж хувиар өндөр байна (Зураг 3.16).

Энэ ялгаа нь хот, хөдөөгийн аль алинд нь байдаг ч хот суурин газрын хүн амын дунд мэдэгдэхүйц өндөр байна. Хотод хамгийн ядуу бүлгийн арван өрхийн зургаа нь гэрт амьдардаг бол хамгийн чинээлэг хэсгийн нэг хувь нь гэрт амьдардаг. Харин чинээлэг өрхүүд дийлэнх нь (84 хувь) төвлөрсөн дулаан болон суурь дэд бүтцийн үйлчилгээгээр хангагдсан орон сууцанд амьдардаг. Эдгээр дэд бүтцийн хүртээмжгүй байдал нь хотын гэр хорооллын айл өрхүүдийг нүүрсний зуух, цахилгаан эрчим хүч гэх мэт үр ашиг багатай, эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг халаалтын эх үүсвэрүүдийг хэрэглэхээс өөр аргагүй байдалд хүргэдэг. Сууцны тусдаа байшин нь гэртэй харьцуулахад арай дээр нөхцөл байдалтай байдаг ч ихэнх нь төвлөрсөн дулаан хангамжгүй, барилгын чанар нь харилцан адилгүй байдаг нь тэдний эдэлгээ, үр ашгийг хязгаарладаг. Хөдөө орон нутагт орон сууц хомс, чинээлэг өрхүүд гэр гэхээсээ илүү тусдаа байшинд амьдрах нь элбэг байна.

Зураг 3. 16 Сууцны төрөл (нийт хүн амын эзлэх хувь), хэрэглээний тэнцүү 5-н бүлгээр, 2022

Манай улсад 2022 онд ядуу арван хүн тутмын ес нь дэд бүтцийн суурь үйлчилгээний аль нэгийг (сайжруулсан ундны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламж, дулааны байнгын эх үүсвэр) авах боломжгүй байна. Улсын хэмжээнд өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангаж чадсан ч (99.9 хувь) бараг бүх ядуу өрх сайжруулсан ариун цэврийн байгууламжгүй, арван хүн тутмын нэг нь халаалтын байнгын эх үүсвэргүй, тэдгээрийг ашиглах боломжгүй байна. Энэ нь ихэвчлэн дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмжийг хязгаарладаг

орон сууцны төрөл (гэр), байршлаас (алслагдсан хөдөө орон нутаг эсвэл хотын гэр хороолол) хамааралтай байна. Хүн амын хамгийн чинээлэг бүлгийн хүмүүсийн дунд ч 22 орчим хувь нь сайжруулаагүй ариун цэврийн байгууламжтай, 16 орчим хувь нь уламжлалт халаалтын эх үүсвэртэй байна. Энэ нь эдийн засгийн хувьд баталгаажсан өрхүүд ч чанартай орон сууц, зохих суурь үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байна гэдгийг онцлон харуулж байгаа ба манай улсын хувьд дэд бүтцийн хөгжилд томоохон бэрхшээлүүд байгааг онцлон харуулж байна.

Зураг 3. 17 Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж, хүн амд эзлэх хувиар, 2022

	а) Сайжруулсан ундны ус	б) Сайжруулсан ариун цэврийн байгууламж	в) Байнгын халаалт
Улсын дундаж	90	33	41
Ядуу	84	5	8
Ядуу бус	92	44	53
Улаанбаатар	100	52	61
Аймгийн төв	96	35	43
Сумын төв	92	10	19
Хөдөө нутаг	49	1	2
Байшин/Орон сууц	96	50	61
Гэр	77	1	1
I	85	3	6
II	83	11	18
III	89	25	35
IV	93	49	60
V	98	78	84

Тайлбар: Байшин/Орон сууц нь байшин, орон сууц эсвэл бусад төрлийн байшинд амьдардаг өрхүүдийг, гэр нь гэрт амьдардаг өрхүүдийг илэрхийлнэ. Эх үүсвэр: ӨНЭЗС 2022

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Amendola, N., G. Mancini, S. Redaelli, G. Vecchi. 2023 "Price Adjustments and Poverty Measurement." World Bank Policy Research Working Paper 10426.
- Balcazar, C.F., L. Ceriaini, S. Olivieri, and M. Ranzani. 2014. "Rent Imputation for Welfare Measurement: A Review of Methodologies and Empirical Findings." World Bank Policy Research Working Paper 7103.
- Belotti, F., G. Mancini, and G. Vecchi. 2022. "Outlier Detection for Welfare Analysis." World Bank Policy Research Working Paper 10231.
- Ceriani, L., S. Olivieri, and M. Ranzani. 2022. "Housing, imputed rent, and household welfare." *The Journal of Economic Inequality*.
- Deaton, A., and S. Zaidi. 2002. "Guidelines for Constructing Consumption Aggregates for Welfare Analysis". World Bank Living Standards Measurement Study (LSMS) Working Paper 135.
- Hentschel J., and P. Lanjouw. 2000. "Household welfare measurement and the pricing of basic services." *Journal of InterУлсын дундаж Development*. Volume 12: 13-27.
- Heston, A., and A. O. Nakamura. 2009. "Questions About the Equivalence of Market Rents and User Costs for Owner Occupied Housing." *Journal of Housing Economics* 18: 273–279.
- Jolliffe, D. 2001. "Measuring Absolute and Relative Poverty: The Sensitivity of Estimated Household Consumption to Survey Design." *Journal of Economic and Social Measurement* Volume 27, no. Numbers 1-2: 1–23.
- Jolliffe, D., D. Gerszon Mahler, C. Lakner, A. Atamanov, and S. Tetteh-Baah. 2022. "Assessing the Impact of the 2017 PPPs on the InterУлсын дундаж Poverty Line and Global Poverty." World Bank Policy Research Working Paper 9941.
- Jolliffe, D., E. Beer Prydz. 2016. "Estimating InterУлсын дундаж Poverty Lines from Comparable Улсын дундаж Thresholds." *Journal of Economic Inequality* 14 (2): 185–198.
- Jolliffe, D., E. Beer Prydz. 2021. "Societal Poverty: A Relative and Relevant Measure." *The World Bank Economic Review* 35, no. 1: 180–206.
- Jolliffe, D., E. Beer Prydz, U. Serajuddin. 2022. "Disparities in Assessments of Living Standards Using Улсын дундаж Accounts and Household Surveys." *Review of Income and Wealth* 68 (S2): S385–S420.
- Jolliffe, D., S. Tetteh-Baah. 2022. "Identifying the Poor— Accounting for Household Economies of Scale in Global Poverty Estimates." World Bank Policy Research Working Paper 10209.
- Mancini, G. and G. Vecchi. 2022. "On the Construction of a Consumption Aggregate for Inequality and Poverty Analysis (English)." Washington, D.C. : World Bank Group.
- Ravallion, Martin. 1998. "Poverty Lines in Theory and Practice." World Bank Living Standards Measurement Study (LSMS) Working Paper 133.
- Ravallion, Martin. 2001. "Poverty lines: Economic foundations of current practices." World Bank, Washington D.C.
- Ravallion, Martin. 2015. "On testing the scale sensitivity of poverty measures." *Economic Letters*, 137 (2015) 88–90
- Ravallion, M. 2020. "On Measuring Global Poverty." *Annual Review of Economics* 12: 167–188.
- Rousseeuw, P. J. and C. Croux. 1993. "Alternatives to the Median Absolute Deviation." *Journal of the American Statistical Association* 88, no. 424: 1273–1283.

ХАВСРАЛТ А.

1. ОНЦГОЙ УТГЫН ЗАСВАРЛАЛТ

Хэрэглээнд онцгой утга байгаа эсэхийг олж тогтоохын тулд Белотти нарын (2022) ерөнхий аргачлалыг ашигласан. Гол хүндрэл нь хэмжилтийн алдаанаас үүдэлтэй онцгой утгыг ялгахад чиглэнэ. Байршлын хувьд медиан, цар хүрээний хувьд квартиль-хоорондын муж зэрэг “сайн” үнэлгээг ашиглах замаар Стата программын (хувьсагч бүрийн хувьд параметрийг нь тохируулна) outdetect командыг ашиглан онцгой утгуудыг илрүүлнэ. Үүнд; онцгой утгыг илрүүлэх зохих түвшинг (орон зайн эсвэл цаг хугацааны бүлэглэл) тодорхойлох, нормчлох болон

статистикийн босго оноо (альфа утга нь 2.5-3.5) хэрэглэх, тухайн бүлэгт 20-иос доошгүй тодорхойлох ажиглалт байгаа тохиолдолд онцгой утгыг тэмдэглэх зэрэг орно. Энэ нөхцөл хангагдаагүй тохиолдолд нэгтгэгдэх түвшинг ахиулан илрүүлэлтийг давтана. Онцгой утгуудыг тодорхойлсны дараа тэдгээрийг орлуулга хийнэ. Ингэхдээ хувьсагч эсвэл шалтгаантай нь уялдуулан бүлгийн медианаар орлуулах, хэвийн мужийн захын утгаар оруулах, эсвэл регресст суурилсан тооцоолол хийнэ.

2. ХҮНСНИЙ ЯДУУРЛЫН ШУГАМЫН САГС

Хүснэгт А. 1

Жишсэн насанд хүрсэн хүний хоногийн хүнсний хэрэглээний сагс

Зүйл	Тоо хэмжээ х Калори	Тоо хэмжээ х Үнэ (төгрөг)
1-р гурил	490.8	231.0
Хонины мах	230.8	1164.4
Цагаан будаа	202.0	210.5
Жигнэмэг	198.2	230.6
Талх	170.0	202.5
Үхрийн мах	95.2	595.4
Ургамлын тос	92.3	84.8
Сүү	90.6	459.7
Гоймон (дотоодын)	62.3	57.8
Төмс	53.7	103.6
Элсэн чихэр	38.0	31.7
Ямааны мах	34.6	182.8
Масло	27.0	30.3
Тараг	18.4	99.0
Ааруул	17.8	69.3

Зүйл	Тоо хэмжээ х Калори	Тоо хэмжээ х Үнэ (төгрөг)
Адууны мах	17.4	108.0
Ундаа	16.7	88.1
Зөөлөн чихэр	13.1	36.6
Өндөг	12.7	75.1
Өрөм	12.2	35.9
Хөлдөөсөн банш	11.9	44.6
Шар тос	10.7	29.5
Борц	9.4	91.0
Сонгино	7.9	55.6
Цувдай	7.5	39.1
Хиам	7.3	22.6
Лууван	6.7	47.9
Тахианы мах	4.8	28.3
Жимсний чанамал	4.2	17.0
Ногоон цай	3.4	43.6
Байцай	3.4	30.0
Лаазалсан мах	2.6	13.6
Алим	2.5	41.5
Зайрмаг	1.9	16.1
Бүгд	1,978.1	4,617.7
Илчлэгийн босго	2,400.0	
Хүнсний ядуурлын шугам		5,602.6

ХАВСРАЛТ Б.

СТАТИСТИКИЙН НЭМЭЛТ ХҮСНЭГТ

Хүснэгт Б. 1 Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 2022

Ядуурлын шугамыг хувилсанаар	Ядуурлын		
	Хамралтын хүрээ	Гүнзгийрэлт	Мэдрэмж
150%	57.9	18.9	8.2
140%	53.0	16.2	6.8
130%	47.1	13.6	5.5
120%	41.0	11.1	4.3
110%	34.1	8.7	3.2
100%	27.1	6.5	2.3
90%	20.6	4.6	1.5
80%	14.4	3.0	0.9
70%	9.1	1.7	0.5
60%	4.8	0.9	0.2
50%	2.1	0.4	0.1

Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 2 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр, 2022

	Улсын дундаж	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	36.5 (1.2)	33.4 (1.1)	24.6 (1.0)	35.3 (1.5)	21.6 (1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	7.9 (0.3)	7.8 (0.3)	5.2 (0.3)	8.8 (0.5)	5.6 (0.4)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	2.6 (0.1)	2.6 (0.1)	1.7 (0.1)	3.2 (0.3)	2.1 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	100.0	13.3	18.1	14.8	7.0	46.9
Хүн амын тоо (мян.хүн)	3,368.6	417.7	607.9	516.6	230.1	1,596.3
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	17.8	22.3	13.4	9.1	37.4
Ядуу хүн амын тоо (мян.хүн)	913.7	162.9	203.7	122.6	82.8	341.7
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.9	3.3	3.1	3.2	3.5
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	48.7	48.7	48.3	48.1	48.8
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	81.0	77.2	74.3	73.4	70.9
Хотжилт (%)	61.4	64.8	56.9	56.8	61.4	64.0
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	26.3	23.9	22.7	24.6	25.4

Тайлбар: Нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2022 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо юм. Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 3 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар, 2022

	Улсын дундаж	Хот			Хөдөө		
		Нийт	Улаан- баатар	Аймгийн төв	Нийт	Сумын төв	Хөдөө нутаг
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	23.0 (0.9)	21.6 (1.2)	26.1 (1.0)	35.5 (0.8)	30.6 (0.9)	41.2 (1.1)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	5.8 (0.3)	5.6 (0.4)	6.1 (0.3)	7.9 (0.2)	7.0 (0.3)	9.0 (0.3)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	2.1 (0.1)	2.1 (0.2)	2.1 (0.1)	2.6 (0.1)	2.4 (0.1)	2.9 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	67.0	46.9	20.1	33.0	17.6	15.4
Хүн амын тоо (мян.хүн)	3 368.6	2 256.7	1 596.3	660.4	1 111.9	592.7	519.2
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	56.8	37.4	19.4	43.2	19.8	23.4
Ядуу хүн амын тоо (мян.хүн)	913.7	518.6	341.7	176.9	395.1	181.4	213.7
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.5	3.5	3.4	3.4	3.2	3.5
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	48.8	48.8	48.7	48.4	49.7	46.8
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	71.2	70.9	71.9	79.4	74.3	85.8
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	25.4	25.4	25.3	23.5	23.1	24.0

Тайлбар: Нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2022 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо юм.
Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 4 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар, 2022

	Улсын дундаж	I улирал	II улирал	III улирал	IV улирал
		(2022 оны 1-3 сар)	(2022 оны 4-6 сар)	(2022 оны 7-9 сар)	(2022 оны 10-12 сар)
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	25.9 (1.2)	27.7 (1.4)	27.0 (1.3)	28.0 (1.3)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	6.1 (0.4)	6.6 (0.4)	6.5 (0.4)	6.7 (0.5)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	2.1 (0.2)	2.3 (0.2)	2.3 (0.2)	2.5 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Хүн амын хувийн жин (%)	100.0	25.7	25.3	24.9	24.1
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	24.5	25.9	24.8	24.8
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.5	3.5	3.5	3.4
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	48.3	48.3	48.6	49.3
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	75.2	73.7	73.5	73.6
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	24.9	25.3	24.8	24.0

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 5 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн ам бүлийн тоогоор, 2022

	Улсын дундаж	Өрхийн ам бүлийн тоо							
		1	2	3	4	5	6	7	8-аас дээш
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	14.1 (0.8)	14.0 (0.7)	19.2 (0.9)	22.5 (0.9)	28.4 (1.0)	39.9 (1.5)	49.2 (2.5)	54.6 (3.3)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	2.9 (0.2)	2.9 (0.2)	4.1 (0.3)	5.0 (0.3)	6.7 (0.3)	10.1 (0.5)	13.1 (1.0)	16.0 (1.2)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	1.0 (0.1)	0.9 (0.1)	1.4 (0.1)	1.7 (0.1)	2.3 (0.1)	3.7 (0.3)	5.0 (0.5)	6.3 (0.7)
Нэмэлт үзүүлэлтүүд:									
Хүн амын хувийн жин (%)	100.0	4.3	11.8	14.7	23.4	21.9	14.9	5.2	3.7
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	2.3	6.1	10.4	19.4	22.9	22.0	9.5	7.5
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	57.5	57.2	47.2	42.3	42.0	43.1	46.2	48.3
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	41.0	69.2	73.3	84.4	88.2	88.5	87.1	86.3
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	0.0	5.4	21.8	36.1	44.2	48.1	45.0	47.8

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 6 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар, 2022

	Улсын дундаж	15 - 29	30 - 39	40 - 49	50 - 59	>=60
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	27.1 (1.5)	26.4 (0.9)	29.8 (1.0)	26.9 (1.1)	24.0 (1.0)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	6.6 (0.4)	5.9 (0.3)	7.4 (0.3)	6.7 (0.4)	5.6 (0.3)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	2.3 (0.2)	1.9 (0.1)	2.7 (0.2)	2.5 (0.2)	1.9 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	100.0	7.2	29.2	28.8	18.5	16.3
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	7.2	28.5	31.6	18.3	14.4
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.2	4.3	4.2	3.1	2.3
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	26.1	34.7	44.4	54.5	68.7
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	83.0	85.2	80.1	72.2	55.7
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	33.5	46.3	30.5	11.8	6.4

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 7 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2022

	Улсын хэмжээнд		Хот		Хөдөө	
	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй
Ядуурлын хамралтын хүрээ	31.3 (1.1)	26.1 (0.7)	28.8 (1.4)	21.3 (0.9)	39.6 (1.5)	34.9 (0.8)
Ядуурлын гүнзгийрэлт	8.3 (0.4)	6.0 (0.2)	7.9 (0.5)	5.2 (0.3)	9.8 (0.5)	7.6 (0.2)
Ядуурлын мэдрэмж	3.1 (0.2)	2.1 (0.1)	3.0 (0.3)	1.9 (0.1)	3.5 (0.3)	2.5 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	19.2	80.8	22.0	78.0	13.6	86.4
Ядуу хүн амын хувийн жин (%)	22.2	77.8	27.7	72.3	15.1	84.9
Өрхийн ам бүлийн дундаж тоо	2.6	3.8	2.7	3.8	2.2	3.7
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	55.1	46.4	54.4	46.5	57.1	46.1
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	18.8	26.8	20.2	27.5	15.2	25.6
Гэрлэсэн, хамтран амьдардаг (%)	18.6	93.9	19.7	94.2	15.2	93.4
Бэлэвсэн, салсан, тусдаа амьдарч байгаа (%)	71.4	4.0	71.0	4.1	73.1	3.8

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 8 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшингээр, 2022

	Улсын дундаж	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Мэргэжлийн	Дээд
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	56.1 (1.6)	48.4 (1.5)	40.9 (1.0)	32.6 (1.2)	21.7 (1.1)	6.3 (0.5)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	13.6 (0.5)	11.4 (0.5)	10.0 (0.4)	8.2 (0.5)	4.9 (0.3)	1.1 (0.1)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	4.6 (0.2)	3.9 (0.3)	3.5 (0.2)	3.1 (0.2)	1.6 (0.1)	0.3 (0.0)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	5.4	6.1	16.2	27.6	17.5	27.2
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	11.2	10.9	24.4	33.3	14.0	6.3
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.6	3.2	3.4	3.6	3.3	3.5
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	49.7	55.5	51.1	47.0	52.1	44.5
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	76.4	68.7	79.8	75.4	70.6	72.2
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	25.5	19.9	20.6	26.3	20.7	29.6

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 9 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар, 2022

	Улсын дундаж	Ажилтай				Ажилгүй	Ажиллах хүчнээс гадуур
		Нийт	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр	Үйлчилгээ		
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	24.2 (0.7)	40.1 (1.1)	22.6 (1.2)	17.6 (0.8)	51.6 4.0	32.3 1.0
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	5.5 (0.2)	8.8 (0.3)	5.4 (0.3)	3.9 (0.2)	13.8 1.5	8.4 0.4
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	1.8 (0.1)	2.9 (0.1)	1.8 (0.2)	1.3 (0.1)	5.6 0.8	3.1 0.2
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	67.1	15.3	20.1	31.8	1.4	31.5
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	59.9	22.5	16.8	20.6	2.7	37.5
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.8	3.8	4.0	3.7	3.9	2.8
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	42.1	44.2	40.5	42.1	41.5	59.1
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	83.1	92.0	90.3	74.7	82.6	59.4
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	31.2	27.5	34.2	31.3	32.6	14.3

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 10 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн салбараар, 2022

	Улсын дундаж	Ажил эрхэлдэг				Ажил эрхлээгүй	Тэтгэмж авагч
		Малчин	Хувийн	Улсын	Төрийн өмчит үйлдвэр		
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	40.9 (1.1)	20.9 (0.9)	18.3 (1.2)	15.9 (1.7)	51.6 (4.0)	32.3 (1.0)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	8.9 (0.3)	4.7 (0.3)	4.4 (0.4)	4.0 (0.6)	13.8 (1.5)	8.4 (0.4)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	2.9 (0.2)	1.5 (0.1)	1.6 (0.2)	1.5 (0.3)	5.6 (0.8)	3.1 (0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:							
Хүн амын хувийн жин (%)	100.0	14.0	35.6	11.9	5.6	1.4	31.5
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	21.1	27.4	8.0	3.3	2.7	37.5
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.8	3.9	3.7	3.9	3.9	2.8
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	44.3	41.5	41.8	41.2	41.5	59.1
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	91.9	82.1	74.4	85.9	82.6	59.4
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	27.0	32.5	31.5	33.2	32.6	14.3

Тайлбар: Тэтгэмж авагч гэдэгт төрөөс ямар нэгэн төрлийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа бүх өрхийн тэргүүлэгчийг хамрууллаа.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Мал аж ахуй эрхлэлт, 2022

Хүснэгт Б. 11

	Үхэр		Адуу		Тэмээ		Хонь		Ямаа		Бод	
	Малтай ерх (%)	Малын дундаж тоо	Малтай ерх (%)	Малын дундаж тоо	Малтай ерх (%)	Малын дундаж тоо	Малтай ерх (%)	Малын дундаж тоо	Малтай ерх (%)	Малын дундаж тоо	Малтай ерх (%)	Малын дундаж тоо
Улсын дундаж	23.0	6.4	18.9	6.5	2.3	6.0	22.6	42.4	23.0	34.3	27.9	19.7
Хот	5.6	4.9	3.4	6.6	0.2	4.7	4.7	29.3	4.5	23.0	7.3	12.0
Хөдөө	58.4	6.7	50.2	6.5	6.5	6.1	59.1	44.5	60.4	36.1	69.7	21.4
Улаанбаатар	2.7	5.0	1.4	6.1	0.0	0.5	1.8	26.2	1.6	17.5	3.3	10.2
Аймгийн төв	12.6	4.9	8.0	6.8	0.5	5.2	11.3	30.4	11.4	24.8	16.7	12.7
Сумын төв	40.0	4.7	28.5	4.7	2.7	5.3	37.6	22.6	38.9	20.7	50.7	11.5
Хөдөө нутаг	79.3	7.9	75.0	7.3	10.8	6.3	83.7	55.7	84.8	44.1	91.5	27.6
Баруун	54.3	3.9	46.0	3.7	7.8	3.2	52.9	29.2	56.5	29.5	64.7	13.7
Хангай	41.4	7.4	34.1	6.1	2.2	7.1	43.9	40.2	43.5	29.8	50.9	19.5
Төв	26.5	6.2	21.0	8.6	4.0	10.8	26.1	56.2	26.5	51.6	34.5	24.0
Зүүн	45.8	10.7	40.4	11.5	3.2	4.1	42.5	66.1	42.1	40.0	49.9	33.1
Ядуу бус	21.2	7.6	17.2	8.0	2.1	7.1	20.2	51.0	20.1	40.2	25.1	23.6
Ядуу	28.0	4.1	23.4	3.6	2.7	3.6	29.2	26.4	30.8	24.0	35.4	12.3

Тайлбар: Малын тоог бодод шилжүүлсэн. Ингэхдээ малыг адуутай адилтгаж тооцдог.
Нэг бод нь нэг адуу, нэг үхэр, 0.67 тэмээ, 6 хонь буюу 8 ямаатай тэнцүү гэж тооцдог. Сарлагийг үхэрт тооцсон.
Эх үүсвэр: ӨНЗЗС 2022.

Хүснэгт Б. 12 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар, 2022

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Малтай	Малгүй	Малтай	Малгүй	Малтай	Малгүй
Ядуурлын хамралтын хүрээ	34.4	24.3	26.1	22.7	36.1	34.2
	(0.8)	(0.8)	(1.8)	(0.9)	(0.9)	(1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	7.3	6.2	5.5	5.8	7.6	8.6
	(0.2)	(0.3)	(0.5)	(0.3)	(0.3)	(0.4)
Ядуурлын мэдрэмж	2.3	2.3	1.8	2.2	2.4	3.1
	(0.1)	(0.1)	(0.2)	(0.1)	(0.1)	(0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	27.9	72.1	7.3	92.7	69.7	30.3
Ядуу хүн амын хувийн жин (%)	35.4	64.6	8.3	91.7	70.9	29.1
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.7	3.4	3.9	3.5	3.6	2.9
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	47.1	49.2	47.6	48.9	47.0	50.8
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	86.1	69.7	82.8	70.4	86.8	66.1
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	25.3	24.6	27.1	25.3	24.9	20.9

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЭС 2022.

Хүснэгт Б. 13 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, газар эзэмшил, өмчлөлийн байдлаар, 2022

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Газартай	Газаргүй	Газартай	Газаргүй	Газартай	Газаргүй
Ядуурлын хамралтын хүрээ	26.8	27.5	24.3	21.5	31.0	43.3
	(0.7)	(0.9)	(1.0)	(1.1)	(0.9)	(1.2)
Ядуурлын гүнзгийрэлт	6.1	7.0	5.9	5.7	6.5	10.3
	(0.2)	(0.3)	(0.3)	(0.4)	(0.3)	(0.4)
Ядуурлын мэдрэмж	2.1	2.5	2.1	2.2	2.1	3.5
	(0.1)	(0.1)	(0.2)	(0.2)	(0.1)	(0.2)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	56.3	43.7	52.8	47.2	63.4	36.6
Ядуу хүн амын хувийн жин (%)	55.6	44.4	55.8	44.2	55.4	44.6
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.6	3.2	3.7	3.3	3.6	3.1
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	49.7	47.4	50.2	47.4	48.9	47.6
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	78.6	68.7	76.1	66.3	82.6	74.6
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.4	25.1	24.8	26.0	23.9	22.9

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЭС 2022.

Хүснэгт Б. 14 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламжийн байдлаар, 2022

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	Хадгаламж -тай	Хадгаламж -гүй	Хадгаламж -тай	Хадгаламж -гүй	Хадгаламж -тай	Хадгаламж -гүй
Ядуурлын хамралтын хүрээ	20.0 (0.9)	31.6 (0.7)	15.5 (1.1)	28.1 (1.0)	30.7 (1.2)	38.1 (0.9)
Ядуурлын гүнзгийрэлт	4.5 (0.3)	7.7 (0.3)	3.7 (0.3)	7.2 (0.4)	6.6 (0.3)	8.6 (0.3)
Ядуурлын мэдрэмж	1.5 (0.1)	2.8 (0.1)	1.3 (0.2)	2.7 (0.2)	2.1 (0.1)	2.9 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:						
Хүн амын хувийн жин (%)	38.6	61.4	40.5	59.5	34.7	65.3
Ядуу хүн амын хувийн жин (%)	28.5	71.5	27.3	72.7	30.0	70.0
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.9	3.2	3.9	3.3	4.0	3.1
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	45.4	50.3	45.8	50.5	44.6	49.9
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	79.7	71.1	77.2	67.8	85.6	76.8
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	32.1	21.0	31.7	21.8	32.9	19.6

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 15 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, зээлийн төрлөөр, 2022

	Улсын дундаж	Зээлтэй								
		Нийт	Цалингийн	Тэтгэврийн	Орон сууцны	Өрхийн хэрэглээний	Малчны	Бизнесийн	Авто машины	Зээлгүй
Ядуурлын хамралтын хүрээ	27.1 (0.6)	25.4 (0.7)	21.0 (0.9)	34.5 (1.6)	3.7 (0.7)	27.1 (2.1)	37.0 (1.2)	9.3 (1.4)	12.3 (1.8)	29.8 (0.9)
Ядуурлын гүнзгийрэлт	6.5 (0.2)	5.8 (0.2)	4.7 (0.3)	8.8 (0.6)	0.5 (0.1)	6.5 (0.7)	7.7 (0.3)	1.8 (0.5)	1.6 (0.4)	7.5 (0.3)
Ядуурлын мэдрэмж	2.3 (0.1)	2.0 (0.1)	1.6 (0.1)	3.3 (0.3)	0.1 (0.0)	2.2 (0.3)	2.4 (0.1)	0.6 (0.3)	0.4 (0.2)	2.7 (0.1)
Нэмэлт үзүүлэлтүүд:										
Хүн амын хувийн жин (%)	100.0	60.7	46.9	13.6	12.4	11.1	18.5	6.3	7.9	39.3
Ядуу хүн амын хувийн жин (%)	100.0	56.9	38.7	18.4	1.8	11.8	27.0	2.3	3.8	43.1
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.4	3.8	4.1	2.8	4.1	4.3	4.1	4.3	4.3	3.0
Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас	48.6	46.0	42.6	61.2	40.9	43.8	44.5	46.1	41.9	51.8
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувийн жин (%)	74.0	79.1	82.9	60.7	84.9	79.9	90.4	84.2	83.6	67.9
Өрхөд хүүхдийн эзлэх хувийн жин (%)	24.8	29.0	33.2	10.5	36.2	33.1	29.8	31.5	35.1	19.6

Тайлбар: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2022.

Хүснэгт Б. 16 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр, 2022

	Улсын дундаж				Хот				Хөдөө			
	Гэр	Орон сууц	Байшин	Бусад	Гэр	Орон сууц	Байшин	Бусад	Гэр	Орон сууц	Байшин	Бусад
